



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
ТУШААЛ

2022 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 108

Улаанбаатар хот

Гүйцэтгэлийн аудитын тайланг  
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаартай “Эрх, үүрэг шилжүүлэх тухай” тушаалын 5 дугаар хавсралт, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Удирдлагын зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын /АГГ-2022/16-ШТА-ГА/ тайлан, албан шаардлагыг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж, зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг бүрэн хангуулж, дүнг 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хариу мэдэгдэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч (Д.Сумьяабазар), Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар (Б.Мөнхбат), Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар (Г.Энхтайван), Нийслэлийн Нийтийн тээврийн үйлчилгээний газар (Ч.Сайханбаяр), Нийслэлийн Замын хөгжлийн газрын дарга (Г.Баярсайхан) -д тус тус зөвлөсүгэй.

3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2022 оны 4 дүгээр улиралд гаргаж танилцуулахыг аудитын гуравдугаар хэлтэс (Э.Мөнхмандах)-т үүрэг болгосугай.

4. Тайланг Үндэсний аудитын газар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Нийслэлийн Нийтийн тээврийн үйлчилгээний газар, Нийслэлийн Замын хөгжлийн газарт тус тус хүргүүлсүгэй.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

М.ЭРДЭНЭЖАРГАЛ



002010035





## НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг баталснаар хэрэгжилт удааширсан, хөрөнгө оруулалтын бус шинж чанартай төсөлд хөрөнгө оруулалт хийж төсвийн хөрөнгийг үр дүнгүй зарцуулсан байна.



**АУДИТЫН СЭДЭВ: УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2021 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН**

Аудитын тайланг бэлтгэсэн:	Товчилсон үг	4-5
Нийслэл дэх Төрийн аудитын газар	Хүснэгтийн жагсаалт	6
Аудитын III хэлтэс	Хавсралтын жагсаалт	6
Хэлтсийн дарга, аудитын менежер:  Э.Мөнхмандах	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	7
Аудитын менежер:  Б.Номинбаатар	Бүлэг 1. А. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх тогтолцоо үр нөлөөтэй байна уу?	8
Ахлах аудитор:  Ж.Жавзанпагма	А.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөх зохистой арга хэмжээг авч байна уу?	8-10
Аудитор: З. Болд  Б.Батбилгүүн	А.2. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, түүнд магадлал хийх тогтолцоо үр дүнтэй байна уу?	10-13
 Т.Шүрэнцэцэг	А.3. Төсөл, арга хэмжээг үр ашигтай төлөвлөх бодлогын хэрэгжилтийг хангуулсан уу?	14-19
Хаяг: УБ хот, Сүхбаатар дүүрэг, Соёлын Төв өргөө "Г" корпус, Утас: 327787	Бүлэг 2. Б. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, улсын төсвөөс олгосон санхүүжилтийн зарцуулалт үр дүнтэй байна уу?	
Тайланг НТАГ-ын <a href="http://www.audit.mn/">http://www.audit.mn/</a> веб сайтаас үзнэ үү.	Б.1. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан уу?	20-25
	Б.2. Захиалагч гэрээний хэрэгжилтийг үр дүнтэй хангуулах ажлыг зохион байгуулсан уу?	25-33
	Б.3. Төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн үү?	33-35
	Б.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын тухайн жилд батлагдсан санхүүжилтийг бүрэн ашиглах зорилгоор Засгийн газраас гарсан шийдвэрийн хэрэгжилт үр дүнтэй байна уу?	35-37

Б.5 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр нөлөөг тооцож байна уу?	37-42
Аудитын дүгнэлт	43
Аудитын зөвлөмж	44
Холбогдох байгууллагын санал	45
Саналд өгсөн тайлбар	46
Хавсралтууд	47-57

## Товчилсон үг

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АТГ	Авлигатай тэмцэх газар
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
БНД	Багануур дүүрэг
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
БХД	Багахангай дүүрэг
БТСУХ	Биеийн тамир, спортын улсын хороо
ЕБ	Ерөнхий боловсрол
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗГ	Засгийн газар
ЗД	Засаг дарга
ЗТХС	Зам тээвэр, хөгжлийн сайд
ЗТХЯ	Зам тээвэр, хөгжлийн яам
ЗАА	Захирагчийн ажлын алба
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУ	Монгол Улс
МУЕС	Монгол Улсын Ерөнхий сайд
НЗХГ	Нийслэлийн замын хөгжлийн газар
НБГ	Нийслэлийн Боловсролын газар
НД	Налайх дүүрэг
НЗД	Нийслэлийн Засаг дарга
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НИТХ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
НХААГ	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар
НХБХГ	Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар
НХОГ	Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар
НЭМГ	Нийслэлийн Эрүүл мэндийн газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТШӨХ	Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТӨӨЗ	Тендерт оролцогчдод өгөх зөвлөмж
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
СС	Сангийн сайд
СБД	Сүхбаатар дүүрэг
СХД	Сонгинохайрхан дүүрэг
УИХ	Улсын Их Хурал
УУХҮС	Уул уурхай, хөнгөн үйлдвэрийн сайд
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХААА	Худалдан авах ажиллагааны алба
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
ХУД	Хан-Уул дүүрэг
ХХААХҮС	Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд

ХЗДХС  
ЧД  
ЭМС

Хууль зүй, дотоод хэргийн сайд  
Чингэлтэй дүүрэг  
Эрүүл мэндийн сайд

## Хүснэгтийн жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
Хүснэгт 1	НЗД-аас ТЕЗ нарт хүргүүлсэн санал	9
Хүснэгт 2	Хөрөнгө оруулалтын шинж чанараар ангилсан байдал	10
Хүснэгт 3	Ажлын даалгаваргүй ТАХ	10
Хүснэгт 4	Зураг төсөл боловсруулахад олгосон зардал	11
Хүснэгт 5	Магадлалаар зураг төсөв баталгаажаагүй ТАХ	12
Хүснэгт 6	Зурагт төсөлгүй болон өөрчлөлт ажлын жагсаалт	13
Хүснэгт 7	Хэрэгцээ шаардлага	14
Хүснэгт 8	Газрын зөвшөөрөл шаардлагатай ТАХ	15
Хүснэгт 9	Төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ	16
Хүснэгт 10	ТАХ-ний мэдээ	16-17
Хүснэгт 11	2021 онд санхүүжүүлсэн ТАХ	17
Хүснэгт 12	Хугацаандаа хэрэгжих боломжгүй байдлаар санхүүжүүлсэн ТАХ	17
Хүснэгт 13	Хөрөнгө оруулалтын бус шинж чанартай ТАХ	18
Хүснэгт 14	Эрх шилжүүлсэн байгууллага, ТАХ-ний тоо	20
Хүснэгт 15	ТАХ-г эрх шилжүүлсэн хугацаа /сараар/	21
Хүснэгт 16	ХАА-г зохион байгуулахад зарцуулсан хугацаа	22
Хүснэгт 17	Үнэлгээ хийсэн тендерийн баримт бичиг	22-23
Хүснэгт 18	Тендерийн баримт бичгийн шаардлагад нийцээгүй ТАХ	24
Хүснэгт 19	Гэрээний дагуу гүйцэтгээгүй ТАХ	26
Хүснэгт 20	Зохиогчийн хяналт хэрэгжүүлсэн ТАХ	29
Хүснэгт 21	Он дамжин хэрэгжиж байгаа ТАХ-ний төрөл	30-31
Хүснэгт 22	Өмнөх оноос дамжиж ирсэн дуусаагүй барилга, байгууламж	32-33
Хүснэгт 23	Захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн байгууллага	33-34
Хүснэгт 24	Санхүүжилт олгосон ТАХ	34-35
Хүснэгт 25	ТЕЗ-ийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан мөнгөн дүн	35
Хүснэгт 26	ЗГ-ын тогтоолоор дуусаагүй ТАХ-ний хөрөнгийг барьцаа дансанд байршуулсан ТАХ	36
Хүснэгт 27	Өмнөх онд байршуулсан барьцаа дансны хөрөнгийг зарцуулсан байдал	37
Хүснэгт 28	Өмч бүртгэл	38
Хүснэгт 29	Төсөвт өртөг нэмэгдсэн он дамжсан ТАХ	39
Хүснэгт 30	Дэд бүтцийн салбарт хэрэгжиж буй ТАХ	42

## Хавсралтын жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
Хавсралт 1	Хэрэгцээ шаардлагаас бага ТАХ-ний жагсаалт	47-50
Хавсралт 2	Санхүүжилтийг хэрэгжих боломжгүй байдлаар баталсан ТАХ-ний жагсаалт	50-53
Хавсралт 3	Гэрээний хэрэгжилт хангалтгүй ТАХ-ний жагсаалт	53-55
Хавсралт 4	Дэд бүтцийн салбарт хэрэгжүүлсэн ТАХ-ний жагсаалт	55-57

<p>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</p>	<p><b>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</b></p> <p>- Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/12 дугаар тушаалыг үндэслэн хийв.</p>
<p>Аудитын зорилт</p>	<p>Аудитын зорилт Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд аудит хийж дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд чиглэгдсэн. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэсэн. Үүнд.</p> <ul style="list-style-type: none"> <li>✚ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх тогтолцоо үр нөлөөтэй байгаа эсэх;</li> <li>✚ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, улсын төсвөөс олгосон санхүүжилтийн зарцуулалт үр дүнтэй байгаа эсэх.</li> </ul>
<p>Аудитын хамарсан хүрээ</p>	<p>Аудитад НЗДТГ, УБ хотын ЗАА, НЗХГ, НБГ, НЭМГ, НХААГ, НӨХГ, “НХОГ” ОНӨААТҮГ, БГД ХААА, БЗД ХААА, БНД ХААА, БХД ХААА, СХД ХААА, ХУД ХААА болон холбогдох бусад газруудыг хамрууллаа.</p>
<p>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</p>	<p>Аудитыг АДБОУС 300, 3000-3100 үндэслэн боловсруулсан гүйцэтгэлийн аудитын журмыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага хийх, асуулга, судалгаа авах, мэдээ, тайланг судалж, санхүүгийн тайлангийн болон нөхцөл байдлын шинжилгээ хийх зэргээр аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, ажлын баримт боловсруулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.</p>
<p>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа</p>	<p>Аудитын гуравдугаар хэлтсийн дарга, аудитын менежер Э.Мөнхмандах хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Б.Номинбаатар хэрэгжүүлж, ахлах аудитор Ж.Жавзанпагма, аудитор З.Болд, Б.Батбилгүүн, Т.Шүрэнцэцэг нар 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийг хүртэл хэрэгжүүлэв.</p>
<p>Аудитын явцад үүссэн хүндрэл бэрхшээл</p>	

## **А 1. А. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨХ ТОГТОЛЦОО ҮР НӨЛӨӨТЭЙ БАЙНА УУ?**

Монгол улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтад "Монгол улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламж"-ийн жагсаалтыг баталснаас холбогдох яамдын ТЭЗ нь 99,401.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 93 ТАХ-г НЗД-д эрх шилжүүлжээ.

### **А.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөх зохистой арга хэмжээг авч байна уу?**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Нийслэлд эрх шилжиж ирсэн ТАХ-ний 70-80% нь Монгол улсын болон ЗГ-ын хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдаагүй, Сангийн яам орон нутагт хэрэгцээ шаардлагатай ТАХ-ний саналын 4.6%-ыг тусгасан байна.


#### **А.1.1. Жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэлтэй нийцэж байна уу?**

2021 онд Нийслэлд эрх шилжиж ирсэн 93 ТАХ-ээс 5,319.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 ТАХ нь өмнөх оноос дамжин ирсэн учир төлөвлөлтийн байдал нь өмнө оны аудитад хамрагдсан.

Аудитад шинээр төлөвлөгдсөн 94,082.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 83 ТАХ-г хамруулж МУ-ын ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, МУ-ын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцсэн эсэхийг тодруулахад нийт ТАХ-ний 70-80% нь бодлогын баримт бичигт нийцээгүй байна. Үүнд:

- МУ-ын ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 24 ТАХ буюу 29% тусгагдаж, 59 ТАХ буюу 71% нь ерөнхий байдлаар болон тусаагүй;
- МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд 16 ТАХ буюу 19% нь тусгагдаж, 67 ТАХ буюу 81% нь ерөнхий байдлаар болон тусаагүй;

Графикаар харуулбал:



ТЭЗ-чид Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих ТАХ-нд орон нутгаас ирүүлсэн саналын 4.6% буюу маш бага ТАХ-г тусгаж, Нийслэл, дүүргийн ИТХ-ын

төлөөлөгчдийн саналыг шууд тусган баталснаас ТАХ-ний 70-80% нь хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдаагүй, орон нутагт хэрэгцээ шаардлагад нийцээгүй, санал, ач холбогдлыг харгалзсан, эрэмбэлсэн эсэх нь эргэлзээтэй байна.

**Дүгнэлт:** Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Нийслэлд эрх шилжиж ирсэн ТАХ-ний 70-80% нь МУ-ын ЗГ-ын хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдаагүй байна.

### **А.1.2. Жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээ нь салбарын бодлого, ТЕЗ-дын саналд үндэслэсэн үү?**

Нийслэлд эрх шилжиж ирсэн 94,082.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 83 ТАХ-ний 25 ТАХ нь НЗД-ын саналд үндэслэсэн байна.

Харин 2021 онд хэрэгжүүлэхээр баталсан нийт ТАХ-ний төлөвлөлт нь МУ-ын сайд болон 10 яамны ТЕЗ-дын чиг үүргийн хүрээний асуудал тул салбарын бодлоготой уялдсан эсэхийг нарийвчлан дүгнэх боломжгүй байна.

### **А.1.3. Сангийн яам ТЕЗ-дын улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг орон нутгийн хэрэгцээ шаардлага, санал хүсэлтийн дагуу эрэмбэлсэн үү?**

Тус дэд зорилтын асуултад дэмжлэг болох зорилгоор СС-ын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам”-ын 3.8<sup>1</sup>, 5.1<sup>2</sup> гэж тус тус заасны дагуу НЗД-аас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 544 ТАХ-ний саналыг хүргүүлсэн, батлагдсан түвшинд аудитын горимыг хэрэгжүүллээ.

**ХҮСНЭГТ №1. НЗД-ААС ТЕЗ НАРТ ХҮРГҮҮЛСЭН САНАЛ**

№	Албан бичгийн огноо, дугаар	Санал хүргүүлсэн байгууллага	Санал болгож буй	Төсөвт туссан	Хувь
1	2020.04.24 01/2058	МУЕС, ЗГХЭГ	6	0	0%
2	2020.04.28 01/2122	МУ-ын ШС	1	0	0%
3	2020.04.27 01/2092, 2020.07.28 02.01/4060	БОАЖС	23	0	0%
4	2020.04.28 01/2123	БХБС	50	3	6%
5	2020.07.27 02-01/4049, 2020.04.28 01/2120	БСШУС	297	20	6.73%
6	2020.04.28 01/2117	ЗТХС	64	1	1.56%
7	2020.04.28 01/2115	УУХҮС	1	0	0%
8	2020.04.28 01/2116, 2020.07.28 02.01/4077	ХХААХҮС	18	0	0%
9	2020.04.28 01/2118	ХНХС	2	0	0%
10	2020.04.28 01/2121	ХЗДХС	2	0	0%
11	2020.04.28 01/2119, 2020.04.28 01/2124, 2020.07.27 02.01/4028	ЭМС	80	1	1.25%
<b>Нийт</b>			<b>544</b>	<b>25</b>	<b>4.6%</b>

НЗД нь 11 ТЕЗ-д шаардлагатай ТАХ-ний санал хүргүүлснээс 4 яамны ТЕЗ 25 ТАХ-ний саналыг хүлээн авч тусгажээ. Энэ нь санал хүргүүлсэн нийт ТАХ-ний дөнгөж 4.6% байна.

ТЕЗ-дад хүргүүлсэн 544 ТАХ-ний саналаас 394 ТАХ-ний санал буюу 72%-ийг хөрөнгө оруулалтын шинж чанараар нь ангилж дүгнэлт хийж үзвэл тоног төхөөрөмж

<sup>1</sup> 3.8 Энэхүү журам, аргачлалын дагуу Аймаг, нийслэлийн засаг дарга нь төслийн саналыг тооцоо судалгаанд үндэслэн холбогдох аргачлалын дагуу үнэлж, эрэмбэлэн сонгосны үндсэн дээр Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ.

<sup>2</sup> 5.1 Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь шинээр хэрэгжүүлэх төсөлд үнэлгээ хийх тухай албан бичгийг хэвлэмэл байдлаар болон цахимаар 4 дүгээр сарын 1-ний дотор ТЕЗ-чид хүргүүлнэ.

худалдан авах ТАХ-ний санал 29, барилга, байгууламж барих ТАХ-ний санал 187, засвар, тохижилтын ажлын ТАХ-ний санал 178 байна.

#### ХҮСНЭГТ №2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИНЖ ЧАНАРААР АНГИЛСАН БАЙДАЛ

№	ТЕЗ	Тоног, төхөөрөмж	Барилга, байгууламж	Засвар, тохижилт	Нийт
1	БХБС	1	8	41	50
2	БОАЖС	5	4	14	23
3	БСШУС	22	166	82	270
4	ЭХС	1	9	41	51
5	Нийт	29	187	178	394

НЗД-ын түүвэрт хамрагдсан ТАХ-ний саналын 178 буюу 45%-д нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх боломжтой барилгын засвар, тохижилт, орцны засварын ажилд улсын төсвийн хөрөнгө оруулалтын саналыг өгсөн нь оновчтой эрэмбэлж, ангилаагүйг харуулж байна.

Цаашид улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих шаардлагатай ажилд Нийслэлээс хүргүүлсэн саналууд ТЕЗ-дын ажлын төсөлд тусгагдахгүй орхигддог байдлыг бууруулах шаардлагатай байна.

**Дүгнэлт:** Сангийн яам орон нутагт хэрэгцээ шаардлагатай ТАХ-ний саналын 4.6%-ыг тусгасан байна.

#### А.2. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, түүнд магадлал хийх тогтолцоо үр дүнтэй байна уу?

Барилга байгууламжийг төлөвлөхдөө зураг төсөл, ажлын даалгаврыг иж бүрэн боловсруулалгүй баталж байгаагаас, зураг төсөл боловсруулах болон өөрчлөлт оруулж баталгаажуулахад хугацаа их зарцуулж байгаагаас магадлал хийх ажиллагаа уялдаагүй, үр дүнгүй байна.

#### А.2.1. Барилга байгууламжийн зураг төсөл зохиох ажлын даалгаврыг орон нутгийн хэрэгцээ шаардлага, инженер геологийн дүгнэлт, бусад холбогдох техникийн нөхцөлүүд, газрын зөвшөөрөл зэргийг үндэслэж иж бүрэн боловсруулсан уу?

9,102.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 31 ТАХ-ний ажлын даалгаврыг боловсруулалгүйгээр ТАХ-г баталж, ХАА-г зохион байгуулахаар эрх шилжүүлжээ.

#### ХҮСНЭГТ №3. АЖЛЫН ДААЛГАВАРГҮЙ ТАХ

№	ТЕЗ	Зураг, төсөл зохиох шаардлагатай		Ажлын даалгаваргүй	
		Тоо	Төсөвт өртөг /сая.төг/	Тоо	Төсөвт өртөг /сая.төг/
1	БХБС	26	21,660.7	2	234.5
2	БСШУС	27	15,589.0	20	2196.0
3	ЗТХС	6	5,516.5	6	5516.5
4	ЗГХЭГ	2	5,750.0	1	750.0
5	ХНХС	2	255.0	1	205.0
6	ЭМС	2	467.8	1	200.0
	Нийт дүн	65	49,239.1	31	9102.0

Барилга байгууламжийн засвар тохижилт, гэрэлтүүлэг, шугам сүлжээний ажлуудад ажлын даалгавар боловсруулж, БШУС-аас эрх шилжүүлж буй сургууль, цэцэрлэгийн барилга барих ТАХ-г загвар зургаар батлуулснаас холболтын зураг боловсруулах шаардлага үүссэн, газрын асуудлыг шийдвэрлээгүй ТАХ-г баталснаас ажлын даалгавар боловсруулах ажил хойшлогдсон байна.

Иймд шинээр барилга, байгууламж барих ТАХ-ний төсөвлөлтийн шаардлагыг хангуулж, ажлын даалгаврыг хугацаанд боловсруулах зайлшгүй шаардлага үүссэн байна. Үүнээс шалтгаалж ТАХ-ний хугацаа хойшлогдох, төсөвт өртөг нэмэгдэх, төсвийн хөрөнгө үр ашиггүй, үр дүнгүй зарцуулагдах эрсдэл үүссэн байна.

**Дүгнэлт:** Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих ТАХ-ний 48% нь барилга байгууламжийн зураг төсөл зохиох ажлын даалгаврыг иж бүрэн боловсруулахгүй байна.

### **А.2.2. Барилга байгууламжийн зураг төслийг мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй хуулийн этгээд боловсруулж, баталгаажуулсан уу?**

Барилга байгууламжийн зураг төслийг Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.21<sup>3</sup>, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.14.6<sup>4</sup>-т тус тус заасны дагуу эрх бүхий байгууллагаас мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж, ахуйн нэгж байгууллага боловсруулж батлуулахаар заасан байна.

Нийслэлд эрх шилжиж ирсэн ТАХ-ээс зураг төсөл шаардлагатай 49,239.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 65 ТАХ-г баталснаас 40,137.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 34 ТАХ-ний зураг төсөлд өөрчлөлт ороогүй анхны зураг төслөөр ТАХ-г хэрэгжүүлж байна.

Харин 9,102.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 31 ТАХ-г батлахдаа загвар зураг төслөөр баталснаас шалтгаалж өөрчлөлт орсон байна.

Эдгээр ТАХ-ний барилга байгууламжийн зургийг мэргэжлийн, эрх бүхий байгууллага гүйцэтгэсэн байна.

**Дүгнэлт:** Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих ТАХ-ний барилга байгууламжийн зураг төслийг тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн эрх бүхий байгууллага гүйцэтгэжээ.

### **А.2.3. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулахад олгосон зардлыг бодит гүйцэтгэл болон зургийн жишиг үнийг үндэслэсэн үү?**

2021 онд 41,787.8 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах 44 ТАХ-ний зураг төслийг гүйцэтгэгчид 593.0 сая төгрөгийн зураг төслийн зардлыг олгожээ.

**ХҮСНЭГТ №4.ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХАД ОЛГОСОН ЗАРДАЛ**

№	ТЕЗ	ТАХ-ний тоо	Гэрээний мөнгөн дүн	Зураг төслийн мөнгөн дүн	/сая.төг/
1	БОАЖС	1	2,850.6		55.0
2	БХБС	17	12,115.7		309.3
3	БШУС	23	24,335.9		156.7
4	МУС, ЗГХЭГ	1	1,782.1		54.0
5	ХНХС	1	193.4		4.0
6	ХХААХҮС	1	510.0		14.0
	<b>Нийт</b>	<b>44</b>	<b>41,787.8</b>		<b>593.0</b>

БХБС болон БШУС-ын захиалгаар хэрэгжүүлж буй түлхүүр гардуулах нөхцөлтэй ТАХ-ний зураг төслийг боловсруулах болон загвар зургаар ТАХ-г хэрэгжүүлэхээр баталснаас холболтын зураг хийх шаардлагатай холбоотойгоор зураг төсвийн үнийг олгосон байна.

<sup>3</sup> 4.1.21."барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл" гэж Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.14-т заасан барилгын чиглэлээр эрх бүхий байгууллагаас олгосон үйл ажиллагаа эрхлэх эрхийг;

<sup>4</sup> 15.14.6 "барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил эрхлэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх";

**Дүгнэлт:** ТАХ-ний зураг төсөв боловсруулахдаа ажлын тоо хэмжээг нарийвчлан тусгаагүй, төсвийн задаргаа байхгүй, ажлын гүйцэтгэх хуваарийг ерөнхий байдлаар гаргаснаас ТАХ-ний барилга байгууламжийн зураг төсөл боловсруулахад олгосон зардлыг нарийвчлан дүгнэх боломжгүй байна.

#### **А.2.4. Барилга байгууламжийн зураг төслийг холбогдох хууль тогтоомж, барилгын норм ба дүрэм, төсвийн үнэ бүрдэл, төсөв зохиох дүрмийн дагуу магадлалаар баталгаажуулсан уу? /Мэргэжлийн шинжээч ажиллуулна/**

Нийслэлд эрх шилжиж ирсэн зураг төсөв шаардлагатай 65 ТАХ-ээс 16,406.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 32 ТАХ-г зураг, төсөлгүй баталсан байна.

**ХҮСНЭГТ №5. МАГАДЛАЛААР ЗУРАГ ТӨСӨВ БАТАЛГААЖААГҮЙ ТАХ**

№	ТЕЗ	Зураг, төсөл зохиох шаардлагатай		Зураг төсөвтэй		Зураг төсөв магадлалаар ороогүй	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
1	БХБЯ	26	21,660.7	24	19,860.7	2	1,800.0
2	БШУЯ	27	15,589.0	6	7,654.0	21	7,935.0
3	ЗТХЯ	6	5,516.5	-	-	6	5,516.5
4	ЗГХЭГ	2	5,750.0	1	5,000.0	1	750.0
5	ХНХЯ	2	255.0	1	50.0	1	205.0
6	ЭМЯ	2	467.8	1	267.8	1	200.0
	<b>Нийт</b>	<b>65</b>	<b>43,234.1</b>	<b>33</b>	<b>32,832.5</b>	<b>32</b>	<b>16,406.5</b>

Зураг төсөлгүй 32 ТАХ-ний төсвийг батлахдаа загвар зураг ашиглан хяналтын төсөв баталж, хээрийн судалгааны ажил хийгээгүйгээс инженер геологийн нөхцөл өөрчлөгдөж ажлын тоо хэмжээ өссөнөөс зураг төсөв дахин боловсруулах шаардлага үүсэж байна.

2021 онд хэрэгжиж дуусахаар батлагдсан ч 2021 оны 8 дугаар сарын 5-ны өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 9-ний хооронд зураг төсөв магадлалаар баталгаажсанаас шалтгаалан ТАХ-ний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж хэрэгжилт 30-60%-тай байна. Тухайлбал:

- СХД-ийн 5-р хороонд баригдах дүүргийн соёлын төв дагуух хатуу хучилттай авто зам, 1.6 км
- СХД-ийн 6-р хороонд баригдах тоосгоны 20 дугаар гудамжнаас Хангай зах хүртэлх хатуу хучилттай авто зам, 1 км СХД, 6 дугаар хороо/
- ЧД-т баригдах автобусны буудлын тохижилт
- СБД-ийн 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20 дугаар хороодод баригдах автобусны буудлын зогсоолын шинэчлэл

Магадлалаар баталгаажаагүй төсөвт өртгөөр худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас үр ашиггүй зардал гарах эрсдэлийг үүсгэж байна.

**Дүгнэлт:** Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ХАА зохион байгуулахаар эрх шилжүүлсэн ТАХ-ний барилга байгууламжийн зураг төслийн 49% нь магадлалаар баталгаажаагүй байна.

#### **А.2.5. Барилга байгууламжийн ажлын зургийг эх загвар зургийн дагуу норм ба дүрэм, стандартын дагуу боловсруулсан эсэхийг мэргэжлийн экспертүүд үнэн зөв хянаж, магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулсан уу?**

Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11<sup>5</sup>, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар

<sup>5</sup> 4.1.11. "барилгын ажил" гэж бүх төрлийн барилга байгууламжийн ажлыг гүйцэтгэх талбайг бэлтгэх, бүрдэл хэсгийг угсрах, шинэчлэн барих, буулгах, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулах үйл ажиллагааг;

зүйлийн 5.1.12<sup>6</sup>-т барилга, байгууламжийн ажлын хуулийн нэр томъёог тодорхойлжээ.

Нийслэлд эрх шилжиж ирсэн 99,401.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 93 ТАХ-ээс 38,730.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 43 ТАХ нь барилга, байгууламжийн ажил байна. Төсөв батлахдаа барилга байгууламжийн ажлын зургийг боловсруулж магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулсан эсэхийг шалгахад дараах байдалтай байна.

**ХҮСНЭГТ №6. ЗУРАГТ ТӨСӨЛГҮЙ БОЛОН ӨӨРЧЛӨЛТ АЖЛЫН ЖАГСААЛТ**

№	ТЕЗ	ТАХ		Зураг төсөвгүй		Зураг төсөвт өөрчлөлт орсон	
		Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг
1	БХБС	12	11,877.4	-	-	12	11,877.4
2	БШУС	21	15,388.0	17	7,770.0	4	7,618.0
3	ЗТХС	4	4,992.0	4	4,992.0	-	-
4	ЗГХЭГ	2	5,750.0	1	750.0	1	5,000.0
5	ХНХС	2	255.0	1	205.0	1	50.0
6	ЭМС	2	467.9	1	200.0	1	267.9
	<b>Нийт</b>	<b>43</b>	<b>38,730.3</b>	<b>24</b>	<b>13,917.0</b>	<b>19</b>	<b>24,813.3</b>

Барилгын зураг төсөв шаардлагатай нийт 43 ТАХ-ээс 13,917.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 24 ТАХ буюу 56%-ийг зураг төсөлгүйгээр баталсан байна.

Төсөв батлахдаа зураг, төсөлтэй батлагдсан 24,813.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 19 ТАХ-ний барилга байгууламжийн ажлын зургийг эх загвар зургийн дагуу норм ба дүрэм, стандартын дагуу боловсруулсан эсэхийг мэргэжлийн экспертүүд үнэн зөв хянаж, магадлалын ерөнхий дүгнэлт гаргуулсан эсэхийг хянахад 52,451.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 16 ТАХ-ний зураг төсөлд өөрчлөлт орж, 19,106.2 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь зураг төсөвтэй нийт ТАХ-ний 37% байна. Зураг төсөв өөрчлөгдөж байгаа шалтгаан нөхцөлийг тодруулахад:

- Төсөв батлагдахад загвар зураг төслөөр баталсан. ТАХ хэрэгжих газар дээр хээрийн судалгааны ажил хийгээгүйгээс инженер геологийн нөхцөл өөрчлөгдөж ажлын тоо хэмжээ нэмэгдсэн. /ялангуяа сургууль, цэцэрлэг/
- Барилгын зургийн тоо хэмжээг буруу тооцоолдог. Жишээ нь 150 ортой хүүхдийн сургууль цэцэрлэг гэж төсөвт суулгаж ТАХ батлагдсаны дараа 250 ортой хүүхдийн цэцэрлэг болгон өөрчилсөн.

Жишээ нь: УБ ЧД-т баригдаж байгаа сургуулийн барилга. Анх төсөв батлахдаа 100 хүүхдийн суудалтай сургуулийн загвар барилгын зургаар төсөв баталж ирүүлсэн ч зураг боловсруулахдаа хээрийн судалгааны ажил хийгээгүйгээс ажлын тоо хэмжээ өссөн.

Барилгын ажлын зураг төсөв, тоо хэмжээ өөрчлөгдөж байгаа зөрчлийн дийлэнх нь БШУС-ын баталсан сургууль, цэцэрлэгийн барилга барих ТАХ байна. Иймд зөвлөмж, албан шаардлага өгөх саналыг ҮАГ-т хүргүүлэхээр шийдвэрлэв.

**Дүгнэлт:** Барилгын зураг төсөв шаардлагатай нийт 43 ТАХ-ээс 24 ТАХ буюу 56%-ийг зураг төсөвгүйгээр баталсан байна

<sup>6</sup> 5.1.12. "барилга байгууламжийн ажил" гэж барилга байгууламжийг барих, өргөтгөл, шинэчлэлт, их засвар болон өрөмдлөг, хайгуул хийх зорилгоор хүн хүч, машин техник, тоног төхөөрөмж, материал, технологийг хослуулан ашиглаж гүйцэтгэх ажлыг;

### А.3.Төсөл, арга хэмжээг үр ашигтай төлөвлөх бодлогын хэрэгжилтийг хангуулсан уу?

Улсын төсвийн хөрөнгөөр Нийслэлд хэрэгжүүлэх ТАХ орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцээгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй, хугацаандаа хэрэгжих боломжгүй байдлаар санхүүжилтийг баталсан байна.

#### А.3.1. Орон нутагт хэрэгцээ шаардлагагүй, эсвэл хэрэгцээ шаардлагаас бага болон их хүчин чадалтай төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн үү?

Төсвийн тухай хуулийн 27<sup>7</sup> дугаар зүйлийн “27.1.3 төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн байх” гэж төсвийн төсөл боловсруулахад баримтлах шаардлагыг тодорхойлжээ. Нийслэлд эрх шилжиж ирсэн ТАХ-ний хэрэгцээ шаардлагыг тодорхойлбол 74,483.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 29 ТАХ нийцэж, 19,598.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 54 ТАХ нийцээгүй байна.

#### ХҮСНЭГТ №7. ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

№	ТЕЗ	Хэрэгцээ шаардлагатай ТАХ		Хэрэгцээ шаардлагагүй ТАХ		Нийт ТАХ	
		Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг
1	БХБС	6	9,297.8	22	12,622.9	28	21,920.7
2	БШУС	8	18,800.0	24	1,199.0	32	19,999.0
3	ЗТХС	1	21,393.9	7	5,576.5	8	26,970.4
4	ЗГХЭГ	4	7,550.0	-	-	4	7,550.0
5	ХНХС	3	355.0	-	-	3	355.0
6	ЭМС	7	17,086.9	1	200.0	8	17,286.9
	<b>Нийт дүн</b>	<b>29</b>	<b>74,483.6</b>	<b>54</b>	<b>19,598.4</b>	<b>83</b>	<b>94,081.9</b>

Нийслэлд эрх шилжиж ирсэн нийт ТАХ-ний 29 нь буюу 34.94% нь нийцэж, 65.1% нь нийцээгүй байна.

Орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцээгүй ажлын дийлэнх хувийг барилгын дээвэр засвар, гадна фасад, орцны завсар, тоглоомын талбайн тохижилт зэрэг ажлууд эзэлж байна. Дэлгэрэнгүйг хавсралтаар.

Жишээ нь: СБД, БНД-үүдэд нийтийн эзэмшлийн орон сууцны орцны засвар хийхээр ТАХ-г баталсан нь хэрэгцээ шаардлагаас бага байна.

Шалтгаан нөхцөлийн тодруулбал НЗД МУ-ын сайд болон холбогдох яамдын ТЕЗ-дад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 544 ТАХ-ний санал хүргүүлснээс 4 яамны ТЕЗ-чид 25 ТАХ буюу нийт саналын 4.6%-ийг тусгаж батлуулсан байна. Нийслэлийн ЗД-ын ТЕЗ-дад хүргүүлсэн ТАХ-ний саналд дүн шинжилгээ хийж үзвэл дийлэнх нь барилгын засвар тохижилтын ажлууд байх бөгөөд иргэд, ААНБ-аас ирж буй саналыг оновчтой эрэмбэлээгүйгээр санал хүргүүлж байгаа нь хэрэгцээ шаардлагыг зөв тодорхойлж чадахгүй байгааг харуулж байна. /Зөвлөмж хүргүүлэх/

Мөн хэрэгцээ шаардлагыг зөв тодорхойлсон боловч гүйцэтгэл хангалтгүй, хэрэгцээнд нийцээгүй ТАХ-г хэрэгжүүлсэн зөрчил илэрч байна. Үүнд:

- БСШУЯ-ны санхүүжилттэй 1,900.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ЧД-ийн 16 дугаар хороонд 100 ортой цэцэрлэгийн барилга худалдан авах. Энэ нь Хүүхдийн цэцэрлэгийн стандартад нийцээгүй, орчны болон эрүүл ахуйн шаардлага хангаагүй байна.

<sup>7</sup> 27. Төсвийн төсөл боловсруулахад тавигдах шаардлага

- ЗГХЭГ-аас 5,000.0 сая төгрөгийн санхүүжилттэй СХД-ийн 3 дугаар хороонд баригдах хөл бөмбөгийн талбай бүхий спортын цогцолборын барилга. Газар чөлөөлөлтийн ажил дуусаагүйгээс өнөөдрийг хүртэл эхлээгүй.

**Дүгнэлт:** Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Нийслэлд хэрэгжүүлэх ТАХ нь орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцээгүй, ТАХ-ний хэрэгжилт хангалтгүй байна.

### А.3.2. Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө төсөвлөлтийн шаардлага хангасан уу?

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4<sup>8</sup>, СС-ын 2016 оны 415 дугаар “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналт” журам-ын 3.2<sup>9</sup>-т ТАХ-ний төсөвлөлтөд тавигдах шаардлагыг тусгажээ.

Нийслэлд эрх шилжиж ирсэн нийт ТАХ-г төрлөөр нь авч үзвэл 74 буюу 80% нь барилга, байгууламж барих, засварын ажил байна. Үүнээс 16,395.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 ажил газрын зөвшөөрөл шаардлагатай байна. Үүнээс 2,816.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ТАХ газрын байршил тодорхойгүй, 6,400.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 газар чөлөөлөлтийн ажил дуусаагүй, 7,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 ТАХ-ний зураг, төсөв, ажлын даалгаврыг боловсруулж дуусаагүй байна.

**ХҮСНЭГТ № 8. ГАЗРЫН ЗӨВШӨӨРӨЛ ШААРДЛАГАТАЙ ТАХ**

№	ТЕЗ	Газрын байршил тодорхойгүй		Газар чөлөөлөлт дуусаагүй		Нийт		ТАХ-г эхлүүлсэн эсэх	
		Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг	Тийм	Үгүй
1	БХБС	-	-	-	-	1	1,000.0	-	2
2	БШУС	-	-	1	1,400.0	3	7,150.0	-	3
3	ЗТХС	3	2,816.5	-	-	4	3,066.5	-	4
4	ЗГХЭГ	-	-	1	5,000.0	1	5,000.0	-	1
	<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>2,816.5</b>	<b>2</b>	<b>6,400.0</b>	<b>9</b>	<b>16,216.5</b>	<b>0</b>	<b>10</b>

Газрын зөвшөөрөл шаардлагатай ТАХ-ний 9 нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй байна. Тухайлбал:

УБ СХД 3-р хороонд баригдах 5,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хөл бөмбөгийн талбай бүхий спортын цогцолборын ажил 2021 оны 8 дугаар сарын 20-нд эхэлж, 2022 оны оны 10 дугаар сарын 31-ний өдөр ажил нь дуусах гэрээтэй. Газар чөлөөлөлт дуусаагүйгээс ажил эхлээгүй.

Газар чөлөөлөлтийн ажил дуусаагүй байхад ТАХ-г баталснаас 2 жил хүлээгдэж буй байдал



<sup>8</sup> 29.4. Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

<sup>9</sup> 3.2. Тухайн санхүүгийн жилд эхлүүлэхээр төлөвлөж буй барилга байгууламж нь 3.1-т заасан зарчмыг баримталсан байхын зэрэгцээ инженер хайгуулын судалгааг хийж, дүгнэлт гаргасан, зураг төслийг экспертизээр батлуулсан, барилга барих газар болон инженерийн шугам, сүлжээний асуудлыг бүрэн шийдсэн, үр ашигтай нь техник, эдийн засгийн үндэслэл, тооцоогоор нотлогдсон зэрэг барилгын ажлыг эхлүүлэх нөхцөлийг хангасан, урсгал зардлын урьдчилсан тооцоо хийгдсэн байна.

Нийслэлд эрх шилжүүлсэн ТАХ ХАА зохион байгуулахад төсөвлөлтийн шаардлага хангаж байсан эсэхийг тодруулахад 46% нь хангаагүй байна.

#### ХҮСНЭГТ №9. ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ТАХ

№	ТЕЗ	/сая.төг/							
		Нийт ТАХ		Зураг төсөлгүй ТАХ		Ажлын даалгаваргүй ТАХ		Зураг төсөлгүй, ажлын даалгаваргүй ТАХ-ний дүн	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
1	БХБЯ	26	21,660.7	2	1,800.0	1	154.5	3	1,954.5
2	БШУЯ	27	15,589.0	21	7,935.0	20	2,196.0	41	10,131.0
3	ЗТХЯ	6	5,516.5	6	5,516.5	6	5,516.5	12	11,033.0
4	ЗГХЭГ	2	5,750.0	1	750.0	1	750.0	2	1,500.0
5	ХНХЯ	2	255.0	1	205.0	1	205.0	2	410.0
6	ЭМЯ	3	817.9	1	200.0	1	200.0	2	400.0
7	Он дамжсан	8	4,154.8	-	-	-	-	-	-
	<b>Нийт дүн</b>	<b>74</b>	<b>53,743.9</b>	<b>32</b>	<b>16,406.5</b>	<b>30</b>	<b>9,022.0</b>	<b>62</b>	<b>25,428.5</b>

Хүснэгтээс харвал 16,406.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 32 ТАХ зураг төсөлгүй, магадлалаар ороогүй, 9,022.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 30 ТАХ ажлын даалгаваргүй байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТХуулийн 48 дугаар зүйлийн 48.3-т “ТЕЗ Улсын төсөв батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор энэ хуулийн 45.4-т заасан худалдан авах бараа, ажил, үйлчилгээний захиалгыг төсөл, арга хэмжээ бүрийн техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийн хамт ХАА-ны мэргэжлийн байгууллагад хүргүүлнэ” гэж заасан шаардлагыг зөрчиж төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-ний жагсаалтыг ХАА-ны газарт хүргүүлсэн байна.

Харин гэрээ байгуулсан ТАХ-ний гэрээний үнийг төсөвт өртөгтэй харьцуулж төсвийг бодитой тооцсон эсэхэд дүн шинжилгээ хийхэд дараах байдалтай байна.

- Батлагдсан төсөвт өртгөөс 10-20%-иар бага үнээр гэрээ байгуулсан 20 ТАХ
- Батлагдсан төсөвт өртгөөс 20 дээш хувиар бага үнээр гэрээ байгуулсан 9 ТАХ байна.

Батлагдсан төсөвт өртгөөс 10%-иас доош үнийн саналтайгаар ТАХ-г хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан нь ТАХ-ний төсөв батлахдаа төсвийг хяналтыг сайжруулж анхаарал хандуулах шаардлагатайг харуулж байна.

**Дүгнэлт:** Нийслэлд шинээр хэрэгжүүлэхээр эрх шилжүүлсэн ТАХ-ний 50% нь төсөвлөлтийн шаардлага хангахгүй байна.

#### А.3.3. Төсөл, арга хэмжээг хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож, санхүүжилтийг батлуулсан уу?

Нийслэлд он дамжсан 255,011.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 132 ТАХ, шинээр хэрэгжих 60,464.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 109 ТАХ нийт 315,476.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 241 ТАХ-г санхүүжүүлэхээр баталжээ.

#### ХҮСНЭГТ №10. ТАХ-НИЙ МЭДЭЭ

№	ТЕЗ	/сая.төг/					
		Өмнөх оноос дамжин хэрэгжих ТАХ		2021 онд шинээр хэрэгжих ТАХ		Нийт дүн	
		Тоо	Төсөвт өртөг /сая.төг/	Тоо	Төсөвт өртөг /сая.төг/	Тоо	Төсөвт өртөг /сая.төг/
1	БОАЖС	1	2,900.0	-	-	1	2,900.0
2	БХБС	81	65,069.3	18	15,892.4	99	80,961.7
3	БШУС	39	136,965.6	34	20,364.0	73	157,329.6
4	ЗТХС	1	21,393.9	3	784.5	4	22,178.4

5	МУЕС, БТСУХ	1	4,000.0	1	5,000.0	2	9,000.0
6	МУС, ЗГХЭГ	3	5,100.0	2	1,050.0	5	6,150.0
7	СС	2	15,532.8	-	-	2	15,532.8
8	ХНХС	-	-	3	355.0	3	355.0
9	ХХААХҮС	1	600.0	-	-	1	600.0
10	ЭМС	3	3,450.0	48	17,019.0	51	20,469.0
	<b>Нийт</b>	<b>132</b>	<b>255,011.6</b>	<b>109</b>	<b>60,464.9</b>	<b>241</b>	<b>315,476.5</b>

2021 онд 241 ТАХ-г санхүүжүүлэхээр 130,320.7 сая төгрөгийг баталж 214 ТАХ-ний 120,319.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгож 25 ТАХ-ний 4,833.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгоогүй байна.

#### ХҮСНЭГТ №11. 2021 ОНД САНХҮҮЖҮҮЛСЭН ТАХ

№	ТЕЗ	2021 онд санхүүжсэн ТАХ	Гэрээний мөнгөн дүн	2020 оны үлдэгдэл санхүүжилт	2021 онд санхүүжих дүн	Олгосон		Олгоогүй	
						Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
1	БОАЖС	1	2,851.0	2,350.6	2,400.0	1	2,350.6	-	-
2	БХБС	99	74,387.6	60,398.6	29,371.1	95	28,594.5	2	45.9
3	БШУС	73	136,941.3	65,507.0	44,829.4	67	41,931.9	6	1,391.0
4	ЗТХС	4	19,637.0	19,637.0	22,178.4	3	19,628.6	1	250.0
5	МУЕС, БТСУХ	2	8,336.5	5,786.5	1,950.0	2	1,950.0	-	-
6	МУС, ЗГХЭГ	5	6,072.3	6,072.3	3,650.0	5	3,616.6	-	-
7	СС	2	16,819.2	9,069.2	7,782.8	2	7,750.6	-	-
8	ХНХС	3	302.7	302.7	250.0	3	208.8	-	-
9	ХХААХҮ С	1	510.0	510.0	300.0	1	300.0	-	-
10	ЭМС	51	16,846.7	16,846.7	17,609.0	35	13,987.7	16	3,147.0
	<b>Нийт</b>	<b>241</b>	<b>282,704.0</b>	<b>186,480.7</b>	<b>130,320.7</b>	<b>214</b>	<b>120,319.5</b>	<b>25</b>	<b>4,833.9</b>

4,833.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 25 ТАХ-ний санхүүжилтийг дараах шалтгаанаар олгоогүй байна. Үүнд:

- 3,583.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 23 ТАХ-ний гүйцэтгэгч сонгон шалгараагүй;
- 1,250.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ТАХ-ний гүйцэтгэгч гэрээний дагуу ажлаа гүйцэтгээгүй;

2021 онд санхүүжих 241 ТАХ-ээс 115,062.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 39 ТАХ-г хугацаандаа хэрэгжих боломжгүй байна.

#### ХҮСНЭГТ №12. ХУГАЦААНДАА ХЭРЭГЖИХ БОЛОМЖГҮЙ БАЙДЛААР САНХҮҮЖҮҮЛСЭН ТАХ

№	ТЕЗ	ТАХ-ний тоо	Батлагдсан төсөвт өртөг	Гэрээний мөнгөн дүн	Үлдэгдэл санхүүжилтийн мөнгөн дүн	2021 онд санхүүжих мөнгөн дүн	
						Тоо	Мөнгөн дүн
1	БХБС	14	21,203.2	20,381.1	19,020.2	5,007.2	
2	БШУС	22	83,359.4	67,492.7	63,467.5	10,401.2	
3	МУЕС, БТСУХ	2	9,000.0	8,336.5	7,200.6	1,950.0	
4	МУС, ЗГХЭГ	1	1,500.0	1,500.0	1,500.0	700.0	
	<b>Нийт дүн</b>	<b>39</b>	<b>115,062.6</b>	<b>97,710.4</b>	<b>91,188.4</b>	<b>18,058.4</b>	

39 ТАХ-ний 2020 оны жилийн эцсийн гэрээний мөнгөн дүнгийн үлдэгдэл 97,710.4 сая төгрөг байхад 2021 онд санхүүжих дүнг 18,058.4 сая төгрөгөөр баталсан нь төсөвт өртгийн 19.8% байна. Жишээ нь:

2018-2022 онд БГД-ийн 19 дүгээр хороонд баригдах 640 хүүхдийн суудалтай барилгыг буулгаж, шинээр барих ТАХ-ний 2020 оны жилийн эцсийн байдлаарх гэрээний үнийн дүнгийн үлдэгдэл 2,088.6 сая төгрөг байхад 2021 онд 50.0 сая төгрөг

- 2019-2022 онд СХД-ийн 20 дугаар хороонд баригдах 480 суудал бүхий сургуулийн барилга барих ТАХ-ний 2020 оны жилийн эцсийн байдлаарх гэрээний үнийн дүнгийн үлдэгдэл 3,490.0 сая төгрөг байхад 2021 онд 50.0 сая төгрөг
  - 2018-2022 онд БГД-т 640 суудал бүхий Эрдмийн өргөө цогцолбор сургуулийн барилга барих ТАХ-ний 2020 оны жилийн эцсийн байдлаарх гэрээний үнийн дүнгийн үлдэгдэл 805,102.9 сая төгрөг байхад 2021 онд 50.0 сая төгрөг
  - 2018-2022 онд СХД-ийн 11 дүгээр хороонд баригдах 150 ортой цэцэрлэгийн барилга барих ТАХ-ний 2020 оны жилийн эцсийн байдлаарх гэрээний үнийн дүнгийн үлдэгдэл 703,406.5 сая төгрөг байхад 2021 онд 50.0 сая төгрөг
  - 2019-2022 онд БЗД-ийн 8 дугаар хороо, Харуул-Алтай хотхонд баригдах 240 ор цэцэрлэгийн барилга барих ТАХ-ний 2020 оны жилийн эцсийн байдлаарх гэрээний үнийн дүнгийн үлдэгдэл 876,554.2 сая төгрөг байхад 2021 онд 50.0 сая төгрөг
  - 2018-2022 онд ХУД-т 150 ортой 4 дүгээр цэцэрлэг цэцэрлэгийн барилга барих ТАХ-ний 2020 оны жилийн эцсийн байдлаарх гэрээний үнийн дүнгийн үлдэгдэл 523,873.2 сая төгрөг байхад 2021 онд 50.0 сая төгрөг
- Энэ нь үнийн өсөлтөөс шалтгаалж ТАХ-ний төсөвт өртөг нэмэгдэх эрсдэлийг үүсгэж байна. Дэлгэрэнгүйг хавсралтаар үзүүлэв.

**Дүгнэлт:** ТАХ-ний санхүүжилтийг хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож санхүүжилтийг батлаагүй байна.

#### **А.3.4. Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл, арга хэмжээг төлөвлөж, батлуулсан уу?**

Нийслэлд эрх шилжсэн 99,401.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 93 ТАХ-ээс 79,220.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 35 ТАХ хөрөнгө оруулалтын шинж чанартай, 20,181.1 сая төгрөгийн төсөвтэй өртөгтэй 57 ТАХ хөрөнгө оруулалтын бус шинж чанартай байна.

**ХҮСНЭГТ №13. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БУС ШИНЖ ЧАНАРТАЙ ТАХ**

№	ТЕЗ	Хөрөнгө оруулалтын шинж чанартай ТАХ-ний жагсаалт		Хөрөнгө оруулалтын бус шинж чанартай ТАХ-ний жагсаалт		Нийт	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
		/сая.төг/					
1	БХБЯ	4	7,223.3	23	14,697.4	27	21,920.7
2	БШУЯ	10	18,900.0	22	1,099.0	32	19,999.0
3	ЗТХЯ	8	26,970.4	-	-	8	26,970.4
4	ЗГХЭГ	3	6,800.0	1	750.0	4	7,550.0
5	Улсын төсөв 2020 он	3	2,725.0	6	2,561.8	9	5,286.8
6	Хот тохижилтын бусад зардал	1	33.0	-	-	1	33.0
7	ХНХЯ	1	100.0	2	255.0	3	355.0
8	ЭМЯ	5	16,469.0	3	817.9	8	17,286.9
	<b>Нийт</b>	<b>35</b>	<b>79,220.7</b>	<b>57</b>	<b>20,181.1</b>	<b>92</b>	<b>99,401.8</b>

Нийт ТАХ-ээс нь 57 буюу 63%, санхүүжилтийн 25.5% нь хөрөнгө оруулалтын бус шинж чанартай байна.

Хөрөнгө оруулалтын бус шинж чанартай ТАХ нь төсөвт өртөг багатай тоо хэмжээ их барилгын дээвэр, засвар, нийтийн орон сууцны орц, фасадын ажил байна. Тухайлбал:

- СБД 5 дугаар хорооны 115.5 сая төгрөгийн төсөвтэй Нийтийн эзэмшлийн орон сууцны орцын их засвар. Ажил гүйцэтгэсэн байдал.



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар үр ашиггүй хөрөнгө оруулалтын бус шинж чанартай ТАХ-г хэрэгжүүлж байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн “6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”; 27 дугаар зүйлийн “27.1.3.төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн байх” заалтуудад нийцэхгүй байна.

Цаашид улсын төсвийн хөрөнгөөр барилгын дээвэр, засвар, нийтийн орон сууцны орц, фасад, тохижилтын ажил гүйцэтгэдэг байдлыг зогсоож эдгээр ажлыг дүүрэг, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж Улсын төсвөөр хөрөнгө оруулалтаар эдийн засгийн үр өгөөжтэй ТАХ-г төлөвлөж батлуулдаг байх талаар шийдвэр гаргаж ажиллаж нь зүйтэй байна.

**Дүгнэлт:** Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хөрөнгө оруулалтын бус шинж чанартай, хэрэгцээ шаардлага бага ТАХ-г баталсан байна.

## **БҮЛЭГ 2. Б.ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, УЛСЫН ТӨСВӨӨС ОЛГОСОН САНХҮҮЖИЛТИЙН ЗАРЦУУЛАЛТ ҮР ДҮНТЭЙ БАЙНА УУ?**

Хөрөнгө оруулалтын арга хэмжээг батлахдаа төсөвлөлтийн шаардлага хангуулаагүй, хугацаа хоцроож эрх шилжүүлсэн, санхүүжилтийг хугацаандаа хэрэгжих боломжгүй байдлаар баталдаг, зураг төсөлд өөрчлөлт оруулдаг зэргээс шалтгаалж төсөл арга хэмжээний хэрэгжилт удааширч, санхүүжилт үр дүнгүй байна.

### **Б.1.Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан уу?**

Хөрөнгө оруулалтаар хэрэгжих ТАХ-г хуульд заасан хугацаанд эрхийг шилжүүлээгүй, төсөвлөлтийн шаардлага хангахгүй ТАХ-г баталсан нь ХАА-г хойшлуулж, улмаар тендерт ирүүлсэн баримт, материалыг үнэн зөвөөр үнэлээгүй байгаа нь гүйцэтгэгчдийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор бүрэн хангаагүйгээс гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа хугацаа алдаж, холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулагдаагүй байна.

#### **Б.1.1. Төсөл, арга хэмжээг хэрэгжих боломжтой хугацаанд эрх шилжүүлсэн үү?**

2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн Монгол улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан "Монгол улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламж"-ийн жагсаалтын дагуу холбогдох яамдаас Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2<sup>10</sup>, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3<sup>11</sup>, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3<sup>12</sup>-т тус тус заасны дагуу 99,401.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 93 ТАХ-г 27 багцад хувааж 116 ТАХ-г Нийслэл, дүүргийн ЗД-д эрх шилжүүлсэн байна.

**ХҮСНЭГТ №14. ЭРХ ШИЛЖҮҮЛСЭН БАЙГУУЛЛАГА, ТАХ-НИЙ ТОО**

№	Эрх шилжүүлсэн байгууллага	ТАХ-ний тоо	Багцалсан ажлын тоо	Багцын тоо	Багцалсан ТАХ-ний тоо	Мөнгөн дүн /сая.төг/
1	БХБЯ	28			28	21,920.7
2	БШУЯ	32	2	8	38	19,999.0
3	ЗТХЯ	8			8	26,970.4
4	ЗГХЭГ	4			4	7,550.0
5	ХНХЯ	3	2	2	5	355.0
6	ЭМЯ	8	2	17	23	17,286.9
7	Он дамжсан	10			10	5,319.8
	<b>Нийт дүн</b>	<b>93</b>	<b>6</b>	<b>27</b>	<b>116</b>	<b>99,401.8</b>

Нийслэлд эрх шилжиж ирсэн ТАХ-ний эрх шилжсэн хугацааг СС-ын 2017 оны 363 тоот тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ ХАА-г төлөвлөх, тайлагнах журам"-ын 2.13<sup>13</sup>-т эрх шилжүүлэх хугацааг төсөв батлагдсанаас хойш 60 хоног, тодотгол орсон бол

<sup>10</sup> 24.2.Монгол Улсын сайд эрх хэмжээнийхээ асуудлаар хууль, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, тэдгээрээс батлан гаргасан бусад шийдвэрт нийцүүлэн тушаал гаргаж, биелэлтийг хангана.

<sup>11</sup> 14.2.3.өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах;

<sup>12</sup> 46.3.Энэ хуулийн 46.2-т заасан захиалагчийг төлөөлөх эрх бүхий этгээд энэ хуулиар өөрт олгогдсон эрхийг холбогдох албан тушаалтанд шилжүүлж болох боловч ийнхүү эрхээ шилжүүлэх нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

<sup>13</sup> 2.13.Захиалагч хуулийн 46.3-т заасны дагуу эрх шилжүүлэх тохиолдолд төсөв батлагдсанаас хойш 60 хоногийн дотор,хэрэв тодотгол орсон бол түүнээс хойш 30 хоногийн дотор тус тус холбогдох албан тушаалтанд шилжүүлсэн байх.

түүнээс хойш 30 хоногийн дотор тус тус холбогдох албан тушаалтанд шилжүүлнэ гэж заасны дагуу тооцов. /журмын дээрх заалт нь тухайн цаг хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан/

Монгол улсын 2021 оны төсвийн тухай хууль 2020 оны 11 дүгээр сарын 13-нд батлагдсанаас хойш хамгийн бага хугацаанд буюу 65 хоногт эрх шилжүүлсэн байна.

**ХҮСНЭГТ №15.ТАХ-Г ЭРХ ШИЛЖҮҮЛСЭН ХУГАЦАА /САРААР/**

№	ТЕЗ	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	9-р сар	11-р сар	Нийт
1	БХБЯ	-	12	11	3	1	1	-	28
2	БСШУЯ	-	30	-	-	-	2	-	32
3	ЗТХЯ	1	7	-	-	-	-	-	8
4	ЗГХЭГ	1	2	-	-	1	-	-	4
5	ХНХЯ	-	3	-	-	-	-	-	3
6	ЭМЯ	-	5	-	-	-	2	1	8
	<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>59</b>	<b>11</b>	<b>3</b>	<b>2</b>	<b>5</b>	<b>1</b>	<b>83</b>

ТАХ батлагдсанаас хойш НЗД-д 2021 оны нэгдүгээр улиралд 61 ТАХ, хоёрдугаар улиралд 16 ТАХ, гуравдугаар улиралд 5 ТАХ, дөрөвдүгээр улиралд 1 ТАХ-ээг ТЕЗ-аас НЗД-д шилжүүлжээ.

ТБОНӨХБАУХАТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1<sup>14</sup>-т барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээг ХАА-г тухайн жилийн төсөв батлагдсан даруйд эхлүүлэхээр заасан байна. Гэвч ТЕЗ-аас онцлог шинж чанартай 58 ТАХ-г 65-201 хоногийн дараа эрхийг шилжүүлсэн нь ТАХ-г төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэх нэг шалтгаан болж байна.

ТЕЗ нар ТАХ-г Нийслэлд хугацаа алдаж эрх шилжүүлж байгаа шалтгаан нөхцөлийг тодруулах боломжгүй байна.

ТАХ хуульд заасан хугацаанд эрх шилжүүлээгүйгээс он дамжих, төсөвт өртөг нэмэгдэх, төсвийн хөрөнгө үргүй зарцуулагдах эрсдэлүүд үүсэж байна. Иймд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний эрх шилжүүлэх хугацаанд анхаарч ажиллах талаар холбогдох газруудад зөвлөмж хүргүүлэхээр ҮАГ-т уламжлав.

**Дүгнэлт:** Хуульд заасан хугацаанд эрхийг шилжүүлээгүйгээс ТАХ хэрэгжих боломж бүрдээгүй байна.

**Б.1.2. Төсөл, арга хэмжээг тайлант онд хэрэгжих боломжийг хангах хугацаанд ХАА-г зохион байгуулсан уу?**

Нийслэлд эрх шилжиж ирсэн 99,401.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 116 ТАХ-ээс шинээр хэрэгжих 94,081.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 106 ТАХ, онд дамжиж ирсэн 5,319.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 ТАХ байна. Үүнээс 83,079.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 86 ТАХ-ний ХАА-г амжилттай зохион байгуулж гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан байна.

Үнэлгээний хороо байгуулагдсанаас хойш ХАА-г зохион байгуулж гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахдаа хамгийн багадаа 9 хоног, хамгийн ихдээ 206 хоногийг зарцуулсан байна.

<sup>14</sup> 46.1.Захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авах талаар дараах эрх, үүрэгтэй байна: 46.1.8.барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг тухайн жилийн төсөв батлагдсан даруйд эхлүүлэх;

**ХҮСНЭГТ №16. ХАА-Г ЗОХИОН БАЙГУУЛАХАД ЗАРЦУУЛСАН ХУГАЦАА**

№	ХАА зохион байгуулсан газар	ТАХ-ний		ХАА зохион байгуулахад зарцуулсан хугацаа /хоног-р/
		Тоо	Төсөвт өртөг /сая.төг/	
1	БНД ХААА	7	1,339.9	46-108
2	БХД ХААА	1	750.0	51
3	БГД ХААА	2	1,550.0	33-96
4	БЗД ХААА	6	570.5	49-200
5	НХААГ	43	50,797.4	0-206
6	СХД ХААА	8	19,392.9	9-179
7	УБЗАА	10	7,674.5	0-65
8	ХУД ХААА	9	665.0	51-190
	<b>Нийт дүн</b>	<b>86</b>	<b>83,079.2</b>	

ХАА-г зохион байгуулахад 1 сараас дээш хугацааг зарцуулсан 72,112.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 74 ТАХ байна. Жишээ нь:

Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй

- СХД-ийн 18 дугаар хороонд баригдах 7,300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 960 хүүхдийн суудалтай сургуулийн барилгыг буулгаж шинээр барих
  - Тендерийн үнэлгээтэй холбоотой гомдол гарснаар дахин зарлагдаж 174 хоног зарцуулсан
- ЧД 16-р хороонд баригдах 1,400.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 100 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилга
  - Газрын чөлөөлөлтийн ажил дуусаагүй учир зураг, төсөв боловсруулах ажлын даалгавар боловсруулаагүй шалтгаанаар тендерийн баримт бичиг боловсруулах ажил хойшилж 144 хоног зарцуулсан

Нийслэлд эрх шилжиж ирсэн ТАХ-ний 46% нь зураг төсөвгүй, ажлын даалгаваргүй, газрын байршил тодорхойгүй, газар чөлөөлөлтийн асуудлыг шийдээгүй төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-ний эрхийг шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэж заасныг зөрчиж ТАХ-г баталснаас ХАА-г хугацаа алдаж хэрэгжих боломжгүйд хүргэж байна.

**Дүгнэлт:** Төсөвлөлтийн шаардлага хангахгүй ТАХ-г баталсан нь ХАА-г хойшлуулж төсөл, арга хэмжээ тайлант онд хэрэгжих боломжгүйд хүргэж байна.

**Б.1.3. Тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу боловсруулж, батлуулж, хэрэгжүүлсэн үү?**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1<sup>15</sup>, 47.3<sup>16</sup>-д тус тус заасны дагуу захиалагч болон эрх шилжүүлж авсан байгууллага үнэлгээний хороо байгуулж, үнэлгээний хороо тендерийн баримт бичгийг боловсруулахаар заасан байна.

Нийслэлд багц болгон задалсан нийт 116 ТАХ-ний 102 ТАХ-нд үнэлгээний хороо тендерийн баримт бичгийг боловсруулж батлуулсан байна.

**ХҮСНЭГТ №17. ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

№	ХАА зохион байгуулсан байгууллага	Баримт бичгийн тоо	Мөнгөн дүн	/сая.төг/
				Түүвэрт хамруулсан
1	БНД ХААА	7	711.3	5
2	БХД ХААА	1	750.0	1
3	БГД ХААА	2	1,550.0	2

<sup>15</sup> 47.1.Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг энэ хуулийн 8.1.1-д заасан дээд хязгаараас давсан тохиолдолд захиалагч үнэлгээний хороо байгуулна.

<sup>16</sup> 47.2.1.техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн урилга, тендерийн баримт бичгийг боловсруулах, тендер хүлээн авах, тендер нээх ажиллагааг холбогдох зааврын дагуу гүйцэтгэх;

4	БЗД ХААА	6	570.5	2
5	НХААГ	50	58,121.1	45
6	НЭМГ	2	1,339.0	2
7	СХД ХААА	9	20,392.9	9
8	УБЗАА	15	11,974.5	15
9	УСУГ ОНӨААТҮГ	1	2,000.0	1
10	ХУД ХААА	9	665.0	4
	<b>Нийт дүн</b>	<b>102</b>	<b>99,401.8</b>	<b>81</b>

Үнэлгээний хороодын боловсруулсан 102 тендерийн баримт бичгийн 81 буюу 79%-д дүн шинжилгээ хийхэд барилга байгууламж болон ажил гүйцэтгэх 40 тендерийн баримт бичигт инженер техникийн ажилчид болон машин механизмд тавигдах шаардлага харилцан адилгүй байна. Үүнд:

Инженер техникийн ажилчдад тавигдах шаардлага:

- Үндсэн ажилтны тоо-40,
- Үндсэн болон гэрээт ажилтны тоо-2,
- Голлох инженер үндсэн байх тоо-26,
- Тусгаагүй-6.

Машин механизмд тавигдах шаардлага:

- өөрийн эзэмшлийн 6,
- 50-60 хувь нь өөрийн эзэмшлийн 10,
- Өөрийн нэр дээр эсхүл түрээс байж болох 15,
- Тодорхой заагаагүй 9 гэх мэтээр ялгавартайгаар шалгуурыг тогтоосон байна.

Ажлын тоо хэмжээ, төсөвт өртөг ойролцоо тендерийн баримт бичигт ТООЗ-ыг ялгавартайгаар боловсруулж батлуулж байгаа нь СС-ын 2014 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн “Журам шинэчлэн батлах” 212 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах” журмын 7.1.1-д заасан “*Үнэлгээний хорооноос боловсруулсан тендерийн баримт бичиг, үнэлгээний дүгнэлтийг хянаж, баталгаажуулах*” үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байна.

Тендерийн баримт бичгийг харилцан адилгүй зарим ТАХ-ний шалгуур үзүүлэлтийг сул боловсруулах нь чадваргүй гүйцэтгэгч шалгарах, ТАХ чанаргүй болох, хугацаандаа хэрэгжихгүй байх зэрэг үр дагаварт хүргэж байна.

Мөн ХАА-г зохион байгуулсан 22 ТАХ-ний үнэлгээний хороо өөрсдийн боловсруулж батлуулсан тендерийн баримт бичгийн ТООЗ-ийн 54 заалтыг зөрчиж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2<sup>17</sup>, 12.3<sup>18</sup> дахь заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

**Дүгнэлт:** Үнэлгээний хороо тендерийн баримт бичгийг хуулийн хугацаанд боловсруулж, батлуулсан ч журмын шаардлагад бүрэн нийцээгүй байна.


#### **Б.1.4. Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан уу?**

2021 онд улсын төсвөөр НЗД-аас 105 ТАХ, дүүргийн ЗД-аас 1 ТАХ-г зохион байгуулах эрх, өмнөх оноос мөн өнгөрөгч оны төсвөөс 10 ТАХ буюу нийтдээ 116 ТАХ-ний ХАА-г зохион байгуулах эрх олгосноос 9 ТАХ нь захирамжаар хүчингүй болж, 2 ТАХ нь зураг төсөв, ажлын даалгаваргүй, 4 ТАХ нь хөрөнгө татагдсанаас ХАА зохион байгуулагдаагүй байна.

<sup>17</sup> 12.2.Захиалагч тухайн тендер шалгаруулалтад тавигдах чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлагыг энэ хуулийн 14-16 дугаар зүйлд нийцүүлэн тогтоож, тендерийн баримт бичигт тусгана.

<sup>18</sup> 12.3.Энэ хуулийн 12.2 дахь хэсэгт заасны дагуу захиалагчийн тогтоосон чадварын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаагүй тендерээс татгалзаж, энэ тухай тендер ирүүлсэн этгээдэд бичгээр мэдэгдэнэ.

Шаардлага хангасан 101 ТАХ-ээс 6 ТАХ-ний тендерийн баримт бичиг боловсруулагдаж, 95 ТАХ-ний ХАА-г амжилттай зохион байгуулж гүйцэтгэчийг сонгон шалгаруулжээ.



ХАА-г зохион байгуулж гүйцэтгэгч сонгон шалгарсан 95 ТАХ-ний тендер шалгаруулалтын баримт бичгийн материалаас 13 ТАХ-ний тендерийн баримт бичгийг АТГ-аас шалгалтын ажил хийж байгаа тул энэ аудитад хамрагдаагүй болно. 82 ТАХ-ний тендер шалгаруулалтын баримт бичиг дээр тулган баталгаажуулалт хийхэд зарим зөрчил илэрч байна.

**ХУСНЭГТ №18. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙН ШААРДЛАГАД НИЙЦЭЭГҮЙ ТАХ**

№	Зохион байгуулагч	Төсөвт өртөг /сая.төг/	ТАХ-ний тоо	14-р зүйл Ерөнхий нөхцөлийг магадлах	15-р зүйл Санхүүгийн чадавхыг үнэлэх	16-р зүйл Техникийн чадавх болон туршлагыг үнэлэх	ХАА-г зохион байгуулах үйл ажиллагаатай холбоотой	Зөрчлийн тоо
1	БНД ХААА	172.7	2	-	-	2	1	3
2	БХД ХААА	750.0	1	-	1	-	-	1
3	БЗД ХААА	170.5	1	-	-	3	-	3
4	НХААГ	1,827.0	7	-	-	18	5	23
5	СХД ХААА	5,267.9	3	-	-	2	1	3
6	УБЗАА	4,230.0	4	-	-	8	-	8
7	ХУД ХААА	205.0	1	1	-	2	-	3
	<b>Нийт</b>	<b>15,203.1</b>	<b>19</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>35</b>	<b>7</b>	<b>44</b>

Жишээлбэл:

СХД-ийн ХААА-аас зохион байгуулсан 4,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй тусгай хэрэгцээт хүүхдийн цэцэрлэгийн барилгын гүйцэтгэхээр шалгарсан ААНБ:

- Ажил гүйцэтгэх ААНБ нь Барилга хот байгуулалтын яамнаас олгодог зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн ЗТ-3.5, 3.6 заалт байхгүй.

НХААГ-аас зохион байгуулсан 92 дугаар сургуулийн Б-блокийн дээврийн их засвар /УБ, БЗД/-н ажлын гүйцэтгэхээр шалгарсан ААНБ:

- ХАБЭА ажилтны сертификатын хугацаа дууссан
- 2018 оны борлуулалтын орлогын мэдээлэл ирүүлээгүй
- Ажлын зураг, төсөл боловсруулах даалгаврын дагуу ажил гүйцэтгэхээр санал болгож буй аргачлалыг ирүүлээгүй
- Ажилчдын нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар ирүүлээгүй
- Гэрчилгээний хуулбар гаргацгүй тодорхой биш

НХААГ-аас зохион байгуулсан 79-р сургуулийн Б-блокийн дээврийн засвар /УБ, БЗД/-н ажлын гүйцэтгэхээр шалгарсан ААНБ:

- Ажил гүйцэтгэх нарийвчилсан хугацааны графикийг ирүүлээгүй
- ХАБЭА ажилтан шаардлагад нийцсэн ажлын туршлагагүй
- Гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмжийн шаардлага хангаагүй гэх мэт зөрчлүүд илэрсэн.

Үнэлгээний хороо тендерийн баримт бичгийг үнэлэхдээ тухайн баримт бичгийг ирүүлсэн, үгүй эсэхийг үнэлж байгаагаас үнэн зөвийг нягтлаагүй байна. Аудитаар хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

**Дүгнэлт:** Тендерт ирүүлсэн баримт, материалыг үнэн зөвөөр үнэлээгүй байгаа нь гүйцэтгэгчдийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор бүрэн хангаагүй байна.

### **Б.1.5. ТЕЗ худалдан авах ажиллагааны тайланг үнэн зөв гаргаж, хугацаанд нь тайлагнаж, шилэн дансаар дамжуулан нийтэд мэдээлсэн үү?**

НХААГ нь Төрийн ХАА-ны цахим систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) болон байгууллагын цахим хуудас [www.ubprocurement.mn](http://www.ubprocurement.mn)-т улсын төсвийн хөрөнгөөр санхүүжиж буй төсөл, арга хэмжээний урилга, үр дүнг байршуулж мэдээлжээ.

2021 онд зохион байгуулсан ХАА-ны тайланг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг ХАА-г төлөвлөх, тайлагнах журам”-ын 4.2-т ТЕЗ, төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээд, ЗГХЭГ нь тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг энэ журмын хавсралтын маягт 2-ын дагуу цахим системд хянан нэгтгэж, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараа оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор цахим системээр ирүүлнэ” гэж заасны дагуу тайланг нэгтгэн боловсруулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-Шинжилгээ үнэлгээний хэлтсээр хянуулан 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 01/179 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлжээ.

Тус тайланд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Нийслэлд эрх шилжиж ирсэн ТАХ-ний төсөвт өртгийг 90,565.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 98 ТАХ байна гэж зөрүүтэй тайлагнасан байна.

**Дүгнэлт:** Нийслэлд эрх шилжсэн ТАХ-ний ХАА-ны тайланг хугацаанд нь тайлагнасан ч зарим тоон мэдээг зөрүүтэй илэрхийлсэн байна.

### **Б.2 Захиалагч гэрээний хэрэгжилтийг үр дүнтэй хангуулах ажлыг зохион байгуулсан уу?**

Төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй ТАХ-ний гэрээний хэрэгжилт, түүнд тавих захиалагчийн хяналтыг хангалтгүй зохион байгуулжээ.

#### **Б.2.1. Гүйцэтгэгч хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг батлагдсан зураг төсөл, төсвөөр захиалагчтай байгуулсан гэрээний дагуу үр дүнтэй гүйцэтгэсэн үү?**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх оноос дамжин хэрэгжиж буй 255,011.6 сая төгрөгийн 132 ТАХ, шинээр хэрэгжих 60,464.9 сая төгрөгийн 109 ТАХ нийт 241 ТАХ-ний гэрээний хэрэгжилтэд доорх 10 байгууллага захиалагчийн хяналтыг хэрэгжүүлжээ.

Аудитаар өмнөх оноос дамжин хэрэгжсэн 142,531.51 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 78 ТАХ, шинээр хэрэгжих 54,504.25 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 45 ТАХ түүвэрт хамруулан гэрээний хэрэгжилтийг тулган баталгаажууллаа.

Гэрээний хэрэгжилтийг талбар дээр тулган баталгаажуулалт хийхэд 102,579.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй 29 ТАХ-ний гэрээний хэрэгжилт хангалтгүй байна. Дэлгэрэнгүйг хавсралтаар харуулав.

**ХҮСНЭГТ №19. ГЭРЭЭНИЙ ДАГУУ ГҮЙЦЭТГЭЭГҮЙ ТАХ**

№	ТЕЗ	Нийт		Зөрчилтэй ТАХ				/сая.төг/
		Тоо	Мөнгөн дүн	Хэрэгжиж дууссан		Хэрэгжиж дуусаагүй		
				Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	
1	БХБС	4	3,078.9	-	-	4	3,078.9	
2	БШУС	16	53,642.2	5	3,752.4	11	49,889.7	
3	ЗТХС	2	2,084.2	-	-	2	2,084.2	
4	МУЕС	1	4,650.6	-	-	1	4,650.6	
5	МУС, ЗГХЭГ	2	3,577.3	-	-	2	3,577.3	
6	СС	1	15,834.4	-	-	1	15,834.4	
7	ХХААХҮС	1	510.0	-	-	1	510.0	
8	ХНХС	2	19,202.2	-	-	2	19,202.2	
	<b>Нийт</b>	<b>29</b>	<b>102,579.8</b>	<b>5</b>	<b>3,752.4</b>	<b>24</b>	<b>98,827.4</b>	

Гэрээний хэрэгжилт хангалтгүй ТАХ-ээс 98,827.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 24 ТАХ нь дуусаагүй байна. Зөрчлийн утгыг түүвэрчлэн харуулбал:

- Хүн амын эрүүл мэндэд ээлтэй эко ариун цэврийн байгууламж /БЗД/




- БНД /138 дугаар цэцэрлэгийн цонх, дээврийн засвар/ комисс ажиллаж хүлээж авсан. Дээврийн засвар дууссаны дараа дусаал гоожсон байдал



- Автобусны буудлын тохижилт /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/ УБ ЧД-т баригдах Автобусны буудлын тохижилтын ажил. Гэрээг 2021 оны 7 дугаар сарын 6-ны өдөр байгуулж ажлын гүйцэтгэл 2022 оны 8 дугаар сарын 30-ны дуусна. Өнөөдрийн байдлаар 17 ширхэг автобусны буудал барьж тохижуулахаас 3 буудалд явган замын хавтан тавьсан байдалтай байна.




- Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 12 дугаар хороо/  
87 хувийн гүйцэтгэлтэй, 95 хувийн санхүүжилт авсан.




Цэцэрлэгийн барилга худалдан авах /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 2 дугаар хороо/

Амины орон сууцыг сургууль болгож тохижуулсан. Ангиар дамжиж хүүхэд гадагш гарах, хүүхдийн цэцэрлэгийн стандартад нийцээгүй барилга байгууламжийг нийлүүлсэн.

Хүүхэд ангиар дамжин гадагш гарахаар байдалтай:



Цэцэрлэгийн барилгын дотор тал стандартын болон чанарын шаардлага хангахгүй байгаа байдал:



БГД Эрдмийн өргөө 640 хүүхдийн суудалтай сургуулийн барилга: Зураг төсөв өөрчилсөн, төсөвт өртөг нэмэгдсэн.



Хэрэгжилт хангалтгүй байгаа нөхцөлийг судлахад дараах шалтгаантай байна.

Үүнд:

- Төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ баталсан.
- Ковид 19 цар тахлын улмаас барилгын материал тасалдаж үнэ өссөн
- Чадваргүй гүйцэтгэгч сонгон шалгаруулсан.
- Гэрээний дагуу захиалагчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж шаардлагатай арга хэмжээг аваагүй.
- ХАА-г хугацаа хоцроож зарласан зэргээс шалтгаалсан байна.

**Дүгнэлт:** Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй ТАХ төсөвлөлтийн шаардлага хангаагүйгээс хэрэгжилт удааширч төсөвт өртөг нэмэгдэх үр дүнгүй байх шалтгаан нөхцөлийг бүрдүүлж байна.

### **Б.2.2. Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх захиалагч, зохиогч, мэргэжлийн байгууллагын хяналт үр дүнтэй хэрэгжсэн үү?**

Нийслэлд зохиогчийн хяналт хэрэгжүүлэх өмнөх оноос дамжин хэрэгжиж байгаа 306,994.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 124 ТАХ, шинээр хэрэгжих 44,499.7

сая төгрөгийн төсөвт өртөгтэй 56 ТАХ-ээс 147,367.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 70 ТАХ-нд хяналт хэрэгжүүлээгүй байна.

**ХҮСНЭГТ №20. ЗОХИОГЧИЙН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТАХ**

№	ТЕЗ	ТАХ-ний хэрэгжих хугацаа	Хяналт хэрэгжүүлсэн		Хяналт хэрэгжүүлээгүй		Нийт дүн	
			тоо	төсөвт өртөг	тоо	төсөвт өртөг	тоо	төсөвт өртөг
1	ЗТХЯ	Он дамжих шинээр	10	7,497.0	8	18,335.5	18	25,832.5
		Он дамжих шинээр	2	1,474.5	1	1,342.0	3	2,816.5
2	СС	Он дамжих шинээр	61	171,671.1	45	109,490.8	106	281,161.9
		Он дамжих шинээр	37	23,483.8	16	18,199.4	53	41,683.2
<b>ОН ДАМЖИХ ШИНЭЭР</b>			71	179,168.1	53	127,826.3	124	306,994.4
<b>НИЙТ ДҮН</b>			110	204,126.4	70	147,367.7	180	351,494.2

Нийслэлд он дамжин болон шинээр хэрэгжиж байгаа 180 ТАХ-ээс 70 ТАХ-нд зохиогчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь нийт ТАХ-ний 39%-ийг эзэлж байна.

Барилгын тухай хуулийн 38<sup>19</sup> дугаар зүйл 38.1.4 “зохиогчийн техникийн хяналтыг барилгын ажлын үе шатанд гэрээний үндсэн дээр гүйцэтгэх” гэж заасан. Өөрөөр хэлбэл зураг төсөв зохиогч нь зураг төсөв зохиох эрх бүхий иргэн, хуулийн этгээд байх тул аудитаар захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн байгууллагаар дамжуулан зохиогчийн хяналт хэрэгжүүлэхтэй холбоотой судалгаа авч дүн шинжилгээ хийлээ.

Өнөөдрийн байдлаар Нийслэлд эрх шилжиж ирсэн ТАХ-тэй холбоотой зохиогчийн хяналтын тайлан мэдээ авдаг болон зохиогчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавьдаг байгууллага байхгүй байна.

Энэ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ТАХ-нд зохиогчийн хяналт хийх гэрээг “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ байгуулж, ажлын үр дүнг дүгнэж, санхүүжилтийг олгож байгаатай холбоотой байна.

Барилгын хөгжлийн төв ТӨҮГ нь гүйцэтгэгчтэй зохиогчийн хяналтын гэрээг байгуулж байгаа нь Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 3.1-д “Захиалагч нь Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан чиг үүргээс гадна дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ”, 3.1.4-т “Барилгын тухай хуулийн 38.1.4-т заасны дагуу зураг төсөл зохиогчтой гэрээг байгуулж, барилгын ажлын үе шатанд зохиогчийн техник хяналт хийлгэн дүгнэлт гаргуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах”, БХБС-ын 2015 оны 185 дугаар тушаалаар баталсан “Барилгын ажлын явцад зохиогчийн хяналт тавих дүрэм”-ийн 2.1-д “Зураг төсөл зохиогч барилгын захиалагчтай гэрээ байгуулан барилгын ажилд зохиогчийн хяналт тавина” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Цаашид захиалагч барилга угсралтын ажилд зохиогчийн хяналт гүйцэтгүүлэх гэрээг зураг төсөл зохиогч компанитай байгуулж, зохиогчийн хяналтыг гүйцэтгүүлэн гэрээний хэрэгжилтийг хангуулж, барилга угсралтын ажлын үе шат бүрд дүгнэлт гаргуулж, үр дүнг тооцон зохих санхүүжилтийг олгож байх шаардлагатай байна.

**Дүгнэлт:** Барилга, байгууламжийн зураг төслийн дагуу зохиогч зохиогчийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан ч зохиогчийн хяналтыг хэрэгжүүлсэн байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналт сул байна.

<sup>19</sup> 38 дугаар зүйл. Зураг төсөл зохиогчийн чиг үүрэг

### Б.2.3. Хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн техник, тоног төхөөрөмжийг техникийн тодорхойлолт, хүчин чадлыг тодорхойлсон баримт бичигт туссан үзүүлэлт, тоо хэмжээгээр хэрэглэгчид бүрэн нийлүүлсэн үү?

2021 онд Нийслэлд өмнөх оноос дамжин хэрэгжсэн 28,263.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 24 ТАХ, шинээр хэрэгжих 29,322.9 төсөвт өртөгтэй 16 ТАХ нийт 57,586.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 40 ТАХ-ний техник, тоног төхөөрөмжийг гэрээний дагуу нийлүүлэхээр байна.

Үүнээс 32,782.9 сая төгрөгийн 34 ТАХ-ний техник, тоног төхөөрөмжийг бүрэн нийлүүлсэн байна. Тухайлбал:

- Хорооны цогцолборын барилга худалдан авах (УБ, БГД, 24 дүгээр хороо)
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх нэг цэгийн төвийн тоног төхөөрөмж /УБ, ХУД 6 дугаар хороо/
- Мэс заслын дурангийн сет тоног төхөөрөмж /УБ, БЗД, Баянзүрх эмнэлэг/
- Сургуулийн гал тогооны тохижилт, тоног төхөөрөмж /УБ, СБД, 71 дүгээр сургууль/ нарыг эрх зүйн баримт бичигт туссаны дагуу хэрэглэгчид бүрэн нийлүүлж хүргэсэн байна.

ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1<sup>20</sup>-т заасны дагуу хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон 32,782.9 сая төгрөгийн 34 ТАХ-ний хөрөнгийг НӨХГ бүртгэж хэрэглэгчдэд тоо хэмжээгээр бүрэн нийлүүлсэн байна.

Харин 24,803.90 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 ТАХ нь Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан хил хаагдсантай холбоотойгоор гэрээний хугацааг сунгасан байна.

**Дүгнэлт:** Нийлүүлэгдэх техник, тоног төхөөрөмж цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалж хэрэглэгчдэд бүрэн нийлүүлэгдээгүй байна.

### Б.2.4. Өмнөх онуудаас хэрэгжиж дуусаагүй орхигдсон барилга, байгууламж, нийлүүлээгүй техник, тоног төхөөрөмж, хийгдээгүй ТЭЗҮ байна уу?

Монгол улсын сайд болон холбогдох 9 яамдын ТЭЗ-аас 2014-2020 онуудад эрх шилжиж ирсэн 278,797.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 148 ТАХ байна. ТАХ-г зориулалтаар харуулав.


**ХҮСНЭГТ №21. ОН ДАМЖИН ХЭРЭГЖИЖ БАЙГАА ТАХ-НИЙ ТӨРӨЛ**

№	ТЕЗ	хатуу болон авто зам барих, зам засвар, шинэчлэл өргөтгөх		Машин, тоног төхөөрөмж, барилга худалдан авах		Барилга, байгууламж		Барилгын засвар, фасад, дээвэр, гэрэлтүүлэг, тохижилтын ажил		Дэд бүтэц, шугам сүлжээ, цахилгаан шат, бусад		Нийт ТАХ	
		тоо	Мөнгөн дүн	тоо	Мөнгөн дүн	тоо	Мөнгөн дүн	тоо	Мөнгөн дүн	тоо	Мөнгөн дүн	тоо	Мөнгөн дүн
1	БОАЖС					1	2,900.0					1	2,900.0
2	БХБС			5	6,250.0			52	12,476.0	25	46,346.9	82	65,072.9
3	БШУС			6	14,750.0	29	120,924.6	4	1,291.0			39	136,965.6
4	ЗТХС	15	24,582.5	1	21,393.9					1	700.0	17	46,676.4
5	МУЕС, БТСУХ					1	4,000.0					1	4,000.0
6	МУС, ЗГХЭГ					2	3,600.0					2	3,600.0

<sup>20</sup> 4.1 “Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний болон хандив, бэлэглэл, тусламжийн хүрээнд бий болсон хөрөнгийг санхүүжилтийн гүйцэтгэлээр эрх бүхий байгууллагын албан бичиг, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт, хөрөнгө тус бүрийн үнийн задаргааг харгалзан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журамд заасны дагуу монгол хэлээр, зөв, оновчтой нэршлээр данс бүртгэлд тусгана”

7	СС				1	14,532.8	1	1,000.0		2	15,532.8		
8	ХХААХҮС								1	600.0	1	600.0	
9	ЭМС			3	3,450.0						3	3,450.0	
<b>НИЙТ ДҮН</b>		<b>15</b>	<b>24,582.5</b>	<b>15</b>	<b>45,843.9</b>	<b>34</b>	<b>145,957.4</b>	<b>57</b>	<b>14,767.0</b>	<b>27</b>	<b>47,646.9</b>	<b>148</b>	<b>278,797.7</b>

Өмнөх оноос дамжин ирсэн ТАХ-ний 145,957.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 34 ТАХ-г барилга, байгууламж эзэлж байна. Энэ нь нийт ТАХ-ний төсөвт өртгийн 52.4%-ийг эзэлж байна. Аудитад он дамжин хэрэгжиж буй дуусаагүй барилга байгууламжийг 100% түүвэрт хамруулав. Хэрэгжилтийн байдлыг графикаар харуулав.



Он дамжин хэрэгжиж буй барилга байгууламжийн 67.5% нь хэрэгжээгүй байна. Хэрэгжилтийн байдлыг газар дээр нь тодруулахад дараах шалтгаантай байна. Үүнд:

- 3,600.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй БГД-ийн 9, 10 дугаар хороонд баригдах 2 ТАХ-ний газар чөлөөлөлтийн ажлыг дуусаагүй байж ТАХ-г баталснаас хэрэгжилт удааширсан, мөн техникийн нөхцөл аваагүйгээс барилгажих талбайн доор шугам хоолой таарсныг зайлуулах шаардлага үүссэн;
- 7,850.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй СБД 13 дугаар хороонд баригдах 960 хүүхэдтэй сургуулийн барилгын дулаан, цахилгааны ажил, 14,532.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй СХД-ийн 5 дугаар хороонд баригдах дүүргийн соёлын ордны барилгын тайзны гэрэлтүүлэг, тоног төхөөрөмжийн ажил нь Соёлын яамны захиалгаар өөр компани гүйцэтгэхээр гэрээ байгуулсан. Өөрөөс хэлбэр тухайн ТАХ-ний ажлыг хэсэгчилж өөр өөр гүйцэтгэгчийг цаг хугацааны хувьд ялгаатайгаар тендер зарласнаас ажил хүлээгдсэн, Мөн Соёлын ордны барилга нь Хүүхэд залуучуудын театр болсонтой холбоотой өрөө тасалгаанд өөрчлөлт орохоор болсон;
- 2,292.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ХУД 4 дүгээр хороонд баригдах 280 ортой цэцэрлэгийн барилга барих ТАХ-ний зураг, төслийг буруу боловсруулж баталснаас инженер геологийн нөхцөл өөрчлөгдөж ажлын тоо хэмжээ нэмэгдсэн.
- Ковид-19 цар тахлын нөлөөллөөс үүдсэн барилгын материалын хомсдол үүсэж үнийн өсөлт нэмэгдсэн, хил хаагдсан зэрэг шалтгаанаар хугацаандаа дуусах боломжгүй болсон
- Техникийн нөхцөл өөрчлөгдсөнөөс шалтгаалан төсөвт өртөг нэмэгдсэн.
- Хөрөнгө татагдсан зэрэг шалтгаантай байна.

ТАХ-ний хэрэгжилт удааширсан дээрх шалтгаан нөхцөлүүдийн дийлэнх нь ТАХ-г батлахдаа төсөвлөлтийн шаардлага хангуулж батлаагүйтэй холбоотой байна. Үүнээс шалтгаалж ТАХ хугацаандаа хэрэгжихгүй байх, үнийн өсөлт дагаж төсөвт өртөг нэмэгдэх нөхцөл үүссэн байна. Дэлгэрэнгүйг хүснэгтээр харуулав.

**ХҮСНЭГТ №22. ӨМНӨХ ОНООС ДАМЖИЖ ИРСЭН ДУУСААГҮЙ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ**

№	ТЕЗ	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Дуусаагүй шалтгаан	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа	Төсөвт өртөг /сая.төг/
1	МУЕС, БТСУХ	Оюуны спортын ордны барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	Төсвийн тодотголоор хөрөнгө он дамжиж тавигдсан	2018	2021	4,000.0
2	МУС, ЗГХЭГ дарга	Хорооны цогцолбор барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 10 дугаар хороо/	Газар чөлөөлөлт бүрэн хийгдээгүйн улмаас ажил удааширсан. Хөрөнгө он дамжин тавигдсан.	2020	2022	1,800.0
3	МУС, ЗГХЭГ дарга	Хорооны цогцолбор барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 9 дүгээр хороо/	Газар чөлөөлөлт бүрэн хийгдээгүйн улмаас ажил удааширсан. Барилгажих талбай дээр дулааны шугам таарсан чөлөөлөх ажил хийгдэж хүлээгдсэн. Хөрөнгө он дамжин тавигдсан.	2020	2022	1,800.0
4	БШУС	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор, 240 суудал /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 19 дүгээр хороо/	Барилга угсралтын ажил 70 хувьтай үргэлжилж байна.	2019	2021	3,485.0
5	БШУС	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 11 дүгээр хороо/	Комиссын дүгнэлт баталгаажих шатанд явж байна.	2018	2021	2,840.0
6	БШУС	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 12 дугаар хороо/	Барилга угсралтын ажил 80 хувьтай үргэлжилж байна.	2018	2021	3,507.0
7	БШУС	Монгол-Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургуулийн оюутны дотуур байрын барилга /Улаанбаатар, Налайх дүүрэг/	Ковид-19 цар тахлын улмаас хил гааль хаагдаж, бараа материалын үнийн өсөлт, хомсдолын улмаас ажил удааширсан. Хөрөнгө он дамжиж тавигдсан.	2019	2021	12,500.0
8	БШУС	Сургуулийн барилга, 1200 суудал /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, Буянт-Ухаа 2 цогцолбор/	Улсын төсөвт Хөрөнгө он дамжиж батлагдсан.	2019	2022	9,697.0
9	БШУС	Сургуулийн барилга, 320 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 31 дүгээр хороо/	Хөрөнгө он дамжсан. Гадна цахилгааны ажлын хөрөнгө тусгагдаагүй.	2018	2021	4,000.0
10	БШУС	Сургуулийн барилга, 320 суудал /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 16 дугаар хороо/	Ажлын явц 57 хувьтай явагдаж байна.	2019	2021	3,700.0
11	БШУС	Сургуулийн барилга, 480 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 20 дугаар хороо/	Хөрөнгө он дамжиж тавигдсан. Нэмэлт хөрөнгө шаардлагатай болсон.	2019	2022	5,852.0
12	БШУС	Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 28 дугаар хороо/	Нэмэлт хөрөнгө шаардлагатай. Хөрөнгө он дамжин тавигдсан.	2018	2021	5,566.0
13	БШУС	Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 4 дүгээр хороо/	Ангиудын шалны хулдаас хил гаалийн асуудлаас болж ирээгүй байна. Спорт болон урлаг заалны шалны материал мөн ирээгүй байна.	2018	2021	6,167.0
14	БШУС	Сургуулийн барилга, 720 суудал /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 12 дугаар хороо/	Ажлын явц 55 хувьтай явагдаж байна.	2019	2022	6,040.0
15	БШУС	Сургуулийн барилга, 960 суудал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 2 дугаар хороо/	Газар чөлөөлөлт хийгдэж, Барилга угсралтын ажил эхэлсэн. Хөрөнгө он дамжин тусгагдсанаас шалтгаалж барилга угсралтын ажил үргэлжилж байна.	2019	2021	6,500.0
16	БШУС	Сургуулийн барилга, 960 суудал /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 13 дугаар хороо/	Гадна цахилгаан. Дулааны асуудал шийдэгдээгүй удсаны улмаас гэрээт хугацаандаа дуусаагүй.	2019	2021	7,850.0
17	БШУС	Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 71 дүгээр сургууль/	Ажлын явц 67 хувьтай явагдаж байна.	2018	2021	1,500.0
18	БШУС	Сургуулийн барилгын өргөтгөл, 640 суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг, Эрдмийн өргөө цогцолбор сургууль/	Хөрөнгө он дамжиж тавигдсан. Нэмэлт хөрөнгө шийдэгдээгүй. Нэмэлт хөрөнгийн гэрээ батлагдах шатандаа хэрэгжиж байна.	2018	2022	5,425.0
19	БШУС	Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 8 дугаар хороо, Гангар инвест/	Газар бүрэн чөлөөлөгдөөгүй, хөрөнгө он дамжин тавигдсаны улмаас ажил удааширсан. Дэлхий даяар Ковид-19 цар тахлын улмаас хил гааль хаагдаж, бараа материалын үнийн өсөлт хомсдолын улмаас ажил удааширсан.	2019	2021	2,500.0
20	БШУС	Цэцэрлэгийн барилга, 280 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 4 дүгээр цэцэрлэг/	Гадна зам талбайн тохижилтын ажлын төсөв 2022 оны төсөвт тусгагдсан.	2018	2022	2,293.0

21	БШУС	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 22 дугаар хороо/1	Хөрөнгө он дамжин тавигдсан. 2021 онд 50 сая төгрөг батлагдсан. 2022 үлдэгдэл хөрөнгө тавигдсан.	2018	2022	1,789.0
22	СС	Дүүргийн соёлын ордны барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 5 дугаар хороо/	Тус барилгын тайзны гэрэлтүүлэг, тоног төхөөрөмжийн ажил нь Соёлын яамны захиалгаар өөр компани гүйцэтгэхээр гэрээ байгуулсан. Мөн Соёлын ордны барилга нь Хүүхэд залуучуудын театр болсонтой холбоотой өрөө тасалгаануудын өөрчлөлт хийгдэхээр болж зураг төслийн даалгаврыг нь Соёлын яам боловсруулж байна.	2019	2021	14,533.0
<b>НИЙТ ДҮН</b>						<b>113,343.0</b>

Аудитын багийн зүгээс албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

**Дүгнэлт:** Төсөвлөлтийн шаардлага хангуулаагүй ТАХ-г баталснаас ТАХ-ний хэрэгжилт удааширсан, төсөвт өртөг нэмэгдсэн байна.

### **Б.2.5.Төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТЭЗҮ, зураг төслийг холбогдох хууль, барилгын норм, дүрэм, стандартын дагуу боловсруулж, 2021 онд холбогдох төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд ашигласан уу?**

Улсын төсвийн 2020 оны ТАХ-ний жагсаалтад ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлыг батлаагүй байна.

### **Б.3. Төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн үү?**

Төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй ТАХ-ний гэрээний хэрэгжилт, түүнд тавих захиалагчийн хяналтыг хангалтгүй зохион байгуулсан, захиалагчийн хяналтын нэгдсэн тайлан, судалгаа байхгүй, хөрөнгө оруулалтын үйл явцад хяналт хэрэгжүүлээгүй байна.

#### **Б.3.1. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих захиалагчийн болон зохиогчийн хяналтын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлж, үе шатны хяналтыг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлж, баталгаажуулж, үр дүнг тооцсон уу?**

ЗГ-ын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга захиалагчийн дүрэм”-ийн 2.2<sup>21</sup>-т захиалагчийн чиг үүрэг хэрэгжүүлэх этгээдийг байнгын ажиллагаатай, эсхүл тухайн барилга байгууламжийн барилгын ажил гүйцэтгэх хугацаагаар байгуулан ажиллуулж болохоор заажээ.

2021 онд Нийслэлд өмнөх оноос эрх шилжиж ирсэн 255,011.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 132 ТАХ, шинээр хэрэгжих 60,464.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 109 ТАХ-нд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

#### **ХҮСНЭГТ №23. ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГУУЛЛАГА**

№	Хяналт хэрэгжүүлсэн байгууллага	Шилжих ТАХ		Шинээр хэрэгжих ТАХ		Нийт дүн	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
1	УБЗАА	5	6,500.0	-	-	5	6,500.0
2	НЗХГ	-	-	3	784.5	3	784.5
3	НБГ	4	1,350.0	5	2,625.0	9	3,975.0
4	НӨХГ	1	450.0	1	300.0	2	750.0
5	ННТҮГ	1	21,393.9	-	-	1	21,393.9
6	НХБХГ	1	200.0	-	-	1	200.0

<sup>21</sup> 2.2.Барилга байгууламжийн хөрөнгө оруулагч захиалагчийн чиг үүрэг хэрэгжүүлэх этгээдийг байнгын ажиллагаатай, эсхүл тухайн барилга байгууламжийн барилгын ажил гүйцэтгэх хугацаагаар байгуулан ажиллуулах бөгөөд Барилгын тухай хуулийн 37.2-т заасан мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх этгээдээр захиалагчийн чиг үүргийг төлөөлүүлэн хэрэгжүүлж болно.

7	НХОГ	104	220,547.7	56	38,886.4	160	259,434.1
8	НЭМГ	3	3,450.0	42	16,819.0	45	20,269.0
9	СХД ЗДТГ	-	-	2	1,050.0	2	1,050.0
10	УБ Лифт	13	1,120.0	-	-	13	1,120.0
	<b>Нийт</b>	<b>132</b>	<b>255,011.6</b>	<b>109</b>	<b>60,464.9</b>	<b>241</b>	<b>315,476.5</b>

Нийслэлийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих ТАХ-ний захиалагчийн хяналтыг дээрх 10 байгууллага хэрэгжүүлжээ. Үүнээс нийт ТАХ-ний 66%-д нь НХОГ-аас захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна. Энэ нь ЗГ-ын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 2.5<sup>22</sup>-д заасан шаардлагад нийцжээ.

Аудитаар захиалагчийн хяналттай холбоотой мэдээ, судалгаа, тайлан болон хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгө бүртгэлийн талаарх мэдээллийг шаардахад НХОГ-ын газраас бусад байгууллага шаардлагатай мэдээ судалгаа, баримт материалыг дутуу ирүүлэх, хөрөнгө оруулалтын нийт ажлын гэрээний хэрэгжилтийн нэгтгэсэн тайлангүй байсан зэрэг нь аудитын явцад хүндрэл учруулж хугацаа алдах эрсдэлийг үүсгэсэн.

Мөн Улсын төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой тайлан мэдээг нэгтгэх, үйл ажиллагаанд хяналт тавих байгууллага байхгүй байгаа нь хяналтын тогтолцоо үр дүнтэй эсэхийг дүгнэх боломжгүйд хүргэж байна.

Захиалагчаас барилга байгууламжийн ажлын хүрээнд ЗГ-ын 2017 оны 170 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 3.9<sup>23</sup>-д заасны дагуу үе шатны хяналтыг хэрэгжүүлэхдээ үе шатны ажлын технологийн дарааллын дагуу холбогдох баримт бичиг, барилгын ажил гүйцэтгэх төлөвлөгөө, график, санхүүжилт зэргийг тухай бүр хянан баталгаажуулсан байна.

**Дүгнэлт:** Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих захиалагчийн болон зохиогчийн хяналт хэрэгжүүлдэг байгууллагын үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлдэггүй, захиалагчийн хяналтын нэгдсэн тайлан, судалгаа байхгүй учир хяналтын тогтолцоог дүгнэх боломжгүй байна.

### Б.3.2. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн, хугацаанд нь бүрэн олгосон уу?

2021 онд 241 ТАХ-г санхүүжүүлэхээр 282,704.0 сая төгрөгийг баталснаас гэрээ байгуулсан 216 ТАХ-ний хэрэгжилтэд 130,320.7 сая төгрөгийг олгож, ажил эхлээгүй болон гэрээний үүргээ зөрчсөн 25 ТАХ-ний 4,833.9 сая төгрөгийг олгоогүй байна.

#### ХҮСНЭГТ №24. САНХҮҮЖИЛТ ОЛГОСОН ТАХ

№	Захиал агч	Гэрээгээр санхүүжих дүн		2021 онд санхүүжих дүн		Алданги тооцож суутгасан		Техник хяналтын зардал олгосон		Зохиогчийн хяналтын зардал	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
		/сая.төг/									
1	ЗАА	1	2,851.0	2	1,900.0	-	-	-	-	-	-
2	НЗХГ	99	74,387.6	3	784.5	1	3.5	2	7.3	-	-
3	НБГ	73	136,941.3	9	2,340.0	-	-	-	-	-	-
4	НӨХГ	4	19,637.0	2	403.0	1	0.8	-	-	-	-
5	НТҮГ	2	8,336.5	1	21,394.0	-	-	-	-	-	-
6	НХБХГ	5	6,072.3	1	135.0	-	-	-	-	-	-

<sup>22</sup> 2.5. Захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх хуулийн этгээд нь мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, ажлын дадлага, туршлага бүхий бүрэлдэхүүнтэй байна. Захиалагч нь хуулийн этгээд бол өөрийн харилцах данс, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудсыг хэрэглэж болно. (Энэ заалтад Засгийн газрын 2018 оны 316 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон)

<sup>23</sup> 3.9. Захиалагч үе шатны ажилд техникийн хяналт тавих, гүйцэтгэлийн тэмдэглэл, ил далд ажлын болон тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохируулга хийсэн акт, санхүүжилтийн тооцоо, холбогдох бусад баримт бичгийг барилгын ажил гүйцэтгэх график, гэрээний дагуу барилгын үйл ажиллагаанд оролцогчтой хамтран хянаж, баталгаажуулахаас гадна техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээдтэй хамтарсан үзлэг шалгалтыг урьдчилан сэргийлэх зорилгоор тухай бүр хийсэн байна.

7	НХОГ	2	16,819.2	139	84,281.0	11	34.2	91	1,036.7	48	435.0
8	НЭМГ	3	302.7	44	17,409.0	-	-	-	-	-	-
9	СХД	1	510.0	2	1,050.0	-	-	1	0.8	-	-
10	УБ	51	16,846.7	13	624.0	-	-	2	8.1	-	-
	Лифт										
	<b>Нийт</b>	<b>241</b>	<b>282,704.0</b>	<b>216</b>	<b>130,320.7</b>	<b>13</b>	<b>38.5</b>	<b>96</b>	<b>1,052.9</b>	<b>48</b>	<b>435.0</b>

2021 онд 96 ТАХ-ний техникийн хяналт хэрэгжүүлсэн 4 байгууллагад 1,052.9 сая төгрөгийг, 48 ТАХ-ний зохиогчийн хяналтын 435.0 сая төгрөгийг НХОГ-уудад олгож, 13 ТАХ-г хэрэгжүүлэх гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй ААНБ-аас 38.5 сая төгрөгийн алданги тооцож санхүүжилтийн дүнгээс суутгасан байна.

**Дүгнэлт:** Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгосон.

### **Б.3.3. Хөрөнгө оруулалтын үйл явцад тавих Засгийн газрын болон ТЕЗ-дын дотоод хяналт, дотоод аудитын хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?**

2021 онд Ковид-19 цар тахлаас шалтгаалан Нийслэлийн дотоод аудитын газар болон НХААГ, НОХГ-ын дотоод аудитын нэгжүүдээс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Нийслэлд эрх шилжиж хэрэгжсэн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлээгүй байна.

### **Б.4 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын тухайн жилд батлагдсан санхүүжилтийг бүрэн ашиглах зорилгоор Засгийн газраас гарсан шийдвэрийн хэрэгжилт үр дүнтэй байна уу?**

#### **Б.4.1. Засгийн газраас урьдчилгаа төлбөрийн баталгаа болон бусад үндэслэлээр ТЕЗ-ийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан санхүүжилтийг төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд үр дүнтэй зарцуулсан уу?**

2021 онд Нийслэлд эрх шилжиж ирсэн 133 ТАХ-ний 53,439.6 сая төгрөгийг ТЕЗ-ийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна. Үүнээс 74 ТАХ-ний 5%-ийн барьцаанд 2,643.1 сая төгрөгийг, 59 ТАХ-ний 50,796.5 сая төгрөгийг ЗГ-ын тогтоолын дагуу байршуулсан байна.

#### **ХҮСНЭГТ №25. ТЕЗ-ИЙН БАРЬЦАА ХӨРӨНГИЙН ДАНСАНД БАЙРШУУЛСАН МӨНГӨН ДҮН**

№	Захиалагч байгууллага	Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан нийт мөнгөн дүн		Барьцаа /5%/		ЗГ-ын тогтоолоор дуусаагүй ТАХ-ний барьцаа	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
1	ЗАА	1	7.3	1	7.3	-	-
2	НЗХГ	2	24.8	2	24.8	-	-
3	НБГ	8	364.6	6	81.7	2	282.9
4	НӨХГ	2	216.9	1	16.9	1	200.0
5	НТҮГ	1	19,140.1	-	-	1	19,140.1
6	НХБХГ	2	60.8	1	52.4	1	8.3
7	НХОГ	99	21,883.5	54	2,227.3	45	19,656.2
8	НЭМГ	16	11,704.4	7	195.4	9	11,508.9
9	СХД	1	2.4	1	2.4	-	-
10	УБ Лифт	1	34.9	1	34.8	-	-
	<b>Нийт</b>	<b>133</b>	<b>53,439.6</b>	<b>74</b>	<b>2,643.1</b>	<b>59</b>	<b>50,796.5</b>

Монгол улсын ЗГ-ын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 397 дугаар тогтоолоор Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын нөлөөллөөс үүдэн улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэхээр батлагдаж гэрээ нь

байгуулагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдлийг ТЕЗ-ийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулж 2022 оны 10 дугаар сарын 30-ны өдөрт багтаан бодит гүйцэтгэлээр санхүүжүүлэхээр СС-дад даалгажээ.

ЗГ-ын тогтоолын дагуу Нийслэлд эрх шилжиж ирсэн 50,796.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 59 ТАХ-ний хөрөнгийг ТЕЗ-ын барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

**ХҮСНЭГТ №26. ЗГ-ЫН ТОГТООЛООР ДУУСААГҮЙ ТАХ-НИЙ ХӨРӨНГИЙГ БАРЬЦАА ДАНСАНД БАЙРШУУЛСАН ТАХ**

№	ТЕЗ	ЗГ-ын тогтоолоор дуусаагүй ТАХ-ний барьцаа	
		Тоо	Мөнгөн дүн /сая.төг/
1	БОАЖС	1	279.8
2	БХБС	21	7,550.8
3	БШУС	26	8,952.1
4	ЗТХС	1	19,140.0
5	МУЕС, БТСУХ	1	1,000.0
6	МУС, ЗГХЭГ	3	456.5
7	СС	1	1,583.4
8	ХНХС	2	39.8
9	ХХААХҮС	1	84.9
10	ЭМС	2	11,708.9
	<b>Нийт</b>	<b>59</b>	<b>50,796.5</b>

Тус дансанд байршуулсан 59 ТАХ-ээс 2,436.7 сая төгрөгийн санхүүжих дүнтэй их засвар, тохижилтын ажил 24, 31,171.7 сая төгрөгийн санхүүжих дүнтэй тоног төхөөрөмжийн ажил 7, 17,188.1 сая төгрөгийн санхүүжих дүнтэй барилга байгууламжийн 28 ажил байна. ЗГ-ын тогтоолын дагуу барьцаа дансанд байршуулсан нийт ажлын 53% нь тоног, төхөөрөмж, их засварын байгаа нь Ковид-19 цар тахлын үед тэвчиж болох зардал бүхий хөрөнгө оруулалтын ажил байна.

Мөн ЗГ-ын дээрх тогтоол нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7<sup>24</sup>, 43 дугаар зүйлийн 43.5<sup>25</sup>, 45 дугаар зүйлийн 45.2<sup>26</sup>, Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8<sup>27</sup> дах заалтуудыг зөрчсөн байна.

**Дүгнэлт:** ЗГ-ын шийдвэрээр барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн хөрөнгийн ТАХ-ний хэрэгжилт хангалтгүй, цаг үеийн онцгой нөхцөл байдалд тэвчиж болох зардлыг царцаасан, холбогдох хуулийн заалтуудыг зөрчсөн байна.

**Б.4.2. Өмнөх онуудад Засгийн газраас ТЕЗ-ийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан хөрөнгийг төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд үр дүнтэй зарцуулсан уу?**

2019-2020 онд Улсын төсвийн хөрөнгөөр өмнөх оноос эрх шилжсэн 48 ТАХ-ний 24,178.1 сая төгрөгийг ЗГ-ын ТЕЗ-дын барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

<sup>24</sup> 7.7.Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ.

<sup>25</sup> Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй.

<sup>26</sup> Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ.

<sup>27</sup> 4.8.Улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх барилга байгууламжид энэ хуулийн 14.3-т заасан хугацаанд гүйцэтгэгчээс хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн тодорхой хувийг уг хугацаа дуустал барьцаалах нөхцөлийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43.6-д заасны дагуу зохицуулна.

**ХҮСНЭГТ №27. ӨМНӨХ ОНД БАЙРШУУЛСАН БАРЬЦАА ДАНСНЫ ХӨРӨНГИЙГ ЗАРЦУУЛСАН  
БАЙДАЛ**

ТАХ	Дууссан		Дуусаагүй			Нийт		/сая.төг/
	Тоо	Барьцаа хөрөнгийн дүн	Тоо	Барьцаа хөрөнгийн дүн	Тоо	Барьцаа хөрөнгийн дүн		
<b>2019 ОНЫ 493 ТАХ</b>	35	17,524.8	6	4,289.9	41	21,814.7		
<b>2020 ОНЫ 253 ТАХ</b>	6	2,287.9	1	75.5	7	2,363.4		
<b>НИЙТ</b>	<b>41</b>	<b>19,812.7</b>	<b>7</b>	<b>4,365.4</b>	<b>48</b>	<b>24,178.1</b>		

Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан 48 ТАХ-ээс 19,812.7 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 41 ТАХ дуусаж, 4,365.4 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 7 ТАХ хэрэгжиж байна.

МУ-ын ЗГ-ын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 397 дугаар тогтоолоор хэрэгжиж дуусаагүй ТАХ-ний санхүүжилтийг ТЕЗ-дын барьцаа хөрөнгийн дансанд байршуулснаас шалтгаалан хэрэгжиж дусаагүй ТАХ-ний хөрөнгийг барьцаа хөрөнгийн данснаас чөлөөлөөгүй байна.

ТАХ-ний барьцаа хөрөнгийг Төсвийн тухай хууль болон Барилгын тухай хуулийн холбогдох заалтуудын дагуу гүйцэтгэгчээс хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн тодорхой хувийг уг хугацаа дуустал барьцаалах нөхцөлтэй. Гэтэл төсөв татагдахаас эрсдэлээс сэргийлж дуусаагүй буюу хэрэгжиж эхлээгүй ТАХ-ний хөрөнгийг барьцаа дансанд он дамжуулан байршуулсан байна.

**Дүгнэлт:** ЗГ-аас ТЕЗ-ийн барьцаа хөрөнгийн дансанд барьцаа хөрөнгийг зориулалт бусаар байршуулж ТАХ-ний санхүүжилт хэлбэрээр олгогдож байна.

### **Б.5 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр нөлөөг тооцож байна уу?**

Барилга байгууламжид захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн бүртгэсэн, байгууллагууд тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг тушаалаар бүртгэж өмчийн бүртгэлд оруулсан ч ТЭЗҮ -г журам байдаггүй, хяналт хэрэгжүүлсэн байгууллагууд бичиг баримтын бүрдэл удаашралтай байна.

Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжих ТАХ-ний төсөвт өртөг нэмэгдсэн байна.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу ажил зохион байгуулсан ч НХААГ, дүүргүүдийн ХААА-дын зөвлөмжийн хэрэгжилт дутуу, ТАХ хэрэгжих боломжтой хугацаанд зохион байгуулаагүй, ХАА-ны эрхийг мэргэжлийн байгууллагад бүрэн шилжүүлээгүй байна.

2021 онд хэрэгжиж дууссан 23 ТАХ-ний хүрээнд дэд бүтцийн салбарын хүчин чадал нэмэгдсэн байна.

#### **Б.5.1. 2021 онд байнгын ашиглалтад орсон барилга байгууламж, нийлүүлсэн техник, тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, ТЭЗҮ-ийг данс бүртгэлд тусгаж, барилга байгууламж, техник тоног төхөөрөмжийг бүрэн хүчин чадлаар нь зориулалтын дагуу ашиглаж байна уу?**

Нийслэлд хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлын НӨХГ-ын судалгаагаар 2021 онд санхүүжсэн 89,034.7 сая төгрөгийн 118 төсөл арга хэмжээ НЗД-д эрх шилжин ирсэн байна. Нийслэлийн өмчид шинээр бий болсон эд хөрөнгийг бүртгэхтэй холбоотой харилцааг зохицуулж буй НИТХТ-ийн 2014 оны 66 дугаар тогтоолоор

батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулах журам”-ын 3.1-т заасны дагуу хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг төсөл хэрэгжсэн хуулийн этгээдийн тайлан баланст бүртгэдэг журмын дагуу бүртгэсэн байна. Үүнд:

- ✓ Он дамжин хэрэгжих /2020-2022/ 55,204.0 төсөвт өртөг бүхий төсөл арга хэмжээний 2021 онд санхүүжих 16,020.2 сая төгрөгийн 25 төсөл арга хэмжээ,
- ✓ Нийслэлийн өмчид бүртгэхгүй /2014-2022/ 33,204.5 төсөвт өртөг бүхий төсөл арга хэмжээний 2021 онд санхүүжих 10,921.1 сая төгрөгийн 19 төсөл арга хэмжээ,
- ✓ НИТХ, НЗД, НӨХГ-ын шийдвэрээр бүртгэлд тусгах 63,357.8 төсөвт өртөг бүхий төсөл арга хэмжээний 2021 онд санхүүжих 46,668.4 сая төгрөгийн 63 төсөл арга хэмжээний 2,261.7 сая төгрөгийн 18 төсөл арга хэмжээг нийслэлийн өмчид бүртгэсэн байна.
- ✓ Өмч эзэмшигч байгууллага нь өөрсдөө бүртгэх 16,930.0 төсөвт өртөг бүхий төсөл арга хэмжээний 2021 онд санхүүжих 15,425.0 сая төгрөгийн 11 төсөл арга хэмжээ байна.

#### ХҮСНЭГТ №28. ӨМЧ БҮРТГЭЛ

№	Өмч бүртгэх газар	2014-2020			2021			/сая.төг/
		Тоо	Төсөв	Санхүүжилт	Тоо	Төсөв	Санхүүжилт	
1	Он дамжин хэрэгжих	6	14.030.0	5.552.2	19	41,297.0	10.468.0	
2	Нийслэлийн өмчид бүртгэхгүй	1	24.949.0	5.000.0	18	8.255.0	5.921.1	
3	НӨХГ зохион байгуулж бүртгэх	2	20.986.6	8.109.7	22	42.371.2.	38.558.7	
4	Байгууллагууд өөрөө бүртгэх	0	0,0	0,0	11	16.930.0	15.425.0	

Эдгээрээс 2022 оны 3 дугаар сарын 31-ны байдлаар 1,500.0 сая төгрөгийн үнэ бүхий 1 барилга байгууламж, 484.1 сая төгрөгийн 2 ш тээврийн хэрэгсэл, засвар, тохижилтын 1,923.4 сая төгрөгийн өртөг бүхий 17 төсөл арга хэмжээ, нийт 3,907.5 сая төгрөгийн 20 төсөл арга хэмжээний үр дүнд шинээр бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авсан байна.

НӨХГ-т бүртгэгдэх 63 ТАХ-ээс 2,261.7 сая төгрөгийн өртөг бүхий 18 ажил бүртгэгдсэн, 45 ажил холбогдох баримт материалыг захиалагч ирүүлээгүйгээс бүртгэгдээгүй иймд ажил дууссан төсөл арга хэмжээний баримт бичгийн бүрдүүлбэрийг хангуулж, шийдвэр гаргуулж бүртгэгдэх ажлыг шуурхай зохион байгуулах шаардлагатай байна.

НБГ нь НЗД-ын 2021 оны А/166, А/167, А/171 дүгээр захирамжуудын дагуу 2021 онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 5 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавин ажилласан байна. Тухайн 5 төсөл, арга хэмжээнээс 2 төсөл, арга хэмжээ нь 2021 онд бүрэн хэрэгжсэн бол 3 төсөл, арга хэмжээ нь 2022 онд он дамжин хэрэгжиж байна.

2021 онд санхүүжих 300 сая төгрөгийг гүйцэтгэгчид шилжүүлсэн, үлдэгдэл барааны үнэ 847,739,400.0 барьцаа дансанд байршуулсан байна.

СБД-ын 16 сургууль, лицей 6 сургуульд 6 нэр бүхий 250 ширхэг тоног төхөөрөмжид сургуулиуд тушаалаар бүртгэсэн байна.

Аудитаар: ЕБ-ын 3, 45 дугаар сургуулиудад Hisense брэндийн зурагт гэмтэл гарсан 3 дугаар сургуулийн зурагт шинээр сольж өгсөн, 45 дугаар сургуулийн зурагт механик гэмтэл ба гараар барьсан газар хагарсан байлаа. Тайлбар авахад: Баталгаа албан ёсны үйлдвэрлэгчийн баталгаа тул хэрэглэгчээс хамаарсан гэмтэл хамаарахгүй тул хариуцахгүй гэлээ. pen tablet-ийг спортын дунд сургууль тушаалаар бүртгээгүй, ашиглалт хангалтгүй, ЕБ-ын 2 дугаар сургууль тушаалаар бүртгэсэн ч ашиглаагүй байлаа.

БЗД-ийн 28 хороонд 5 багц төсөл, арга хэмжээний 2021 онд 1,21.0 сая төгрөгийн 36 нэр төрлийн 425 тоног төхөөрөмжийг тушаалаар бүртгэсэн, онд дамжин хэрэгжих ажлын гэрээний үнийн дүн 1,220.6 сая төгрөг НБГ-ын газрын барьцаа дансанд байна.

Зураг болон ТЭЗҮ-г бүртгэх журам байдаггүй бөгөөд өндөр дүнтэй ажлын зураг, төслийг байгууллагууд бүртгэсэн байдаг.

**Дүгнэлт:** Захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн байгууллагуудын баримт бичгийн бүрдэл удаашралтай байгаагаас өмч хугацаандаа бүртгэгдэхгүй байна.

### **Б.5.2. Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд болон он дамжин хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний төсөвт өртөг үндэслэлгүйгээр нэмэгдсэн үү?**

СС-ын 2016 оны 415 дугаар “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 3.11-т “*Барилгын материалын үнэ болон ханшны өөрчлөлт, бусад хүчин зүйлээс хамааран барилга байгууламжийн төсвийн тооцоонд өөрчлөлт оруулах тохиолдолд санхүү, эдийн засгийн болон барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд хамтран үндэслэл, тооцоог хянаж, санхүүжүүлэх асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэнэ*” гэж заажээ.

Нийслэлд 2018-2021 онд эрх шилжиж ирсэн 52,451.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 16 ТАХ-ний төсөвт өртөг 19,106.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

**ХҮСНЭГТ №29. ТӨСӨВТ ӨРТӨГ НЭМЭГДСЭН ОН ДАМЖСАН ТАХ**

№	ТЕЗ	ТАХ-ний тоо	Анх батлагдсан төсөвт өртөг	/сая.төг/	
				Нэмэгдсэн төсөвт өртөг	Нийт дүн
1	БСШС	15	42,571.8	14,453.4	57,025.2
2	СС	1	9,880.0	4,652.8	14,532.8
	<b>Нийт</b>	<b>16</b>	<b>52,451.8</b>	<b>19,106.2</b>	<b>71,558.0</b>

Төсөвт өртөг нэмэгдсэн 15 ТАХ БСШУС-аас эрх шилжиж ирсэн сургууль, цэцэрлэгийн барилга байна. Шалтгаан нөхцөлийг газар дээр нь тодруулахад дараах байдалтай байна. Үүнд:

- Төсөв батлахдаа нэг загварын зураг төслөөр барилгын ажлыг төлөвлөж, хээрийн судалгааны ажил хийгээгүйгээс энгийн хөрсөөр хяналтын төсвийг тооцсоноос инженер, геологийн нөхцөл өөрчлөгдөж ажлын тоо хэмжээ өссөн;



- Сургууль цэцэрлэгийн барилгын хүчин чадлыг дутуу тооцож хүүхдийн тоо хэмжээг нэмэгдүүлснээр ажлын тоо хэмжээ өссөн;

**Дүгнэлт:** Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжих ТАХ-ний төсөвт өртөг нэмэгдсэн байна.

### **Б.5.3. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан уу?**

“Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн, үр ашиг” аудитын хүрээнд НЗД бөгөөд УБ хотын захирагч Д.Сумъяабазарт 3, НХААГ, дүүргийн ХААА-дад 3, НХОГ ОНӨААТҮГ-т 1 нийт 7 зөвлөмж хүргүүлэхэд биелэлтийг дараах байдлаар ирүүлсэн байна. Үүнд:

**НЗД бөгөөд УБ хотын захирагч /Д.Сумъяабазар/-д.**

- 1. ТЕЗ-аас шилжин ирсэн ТАХ-г хэрэгжих боломжтой хугацаанд зохион байгуулж хэвших. /Эрхийг мэргэжлийн байгууллагад нь шилжүүлэх/ 2021.12.06 03/5485 албан тоотор НТАГ-т ирүүлсэн.

МУ-ын 2021 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 10 ТЕЗ-ын тушаалаар 99,401.78 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 93 ТАХ НЗД-д шилжин ирсэн байна. ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1-т "Барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээг ХАА-г хугацаа алдалгүй эхлүүлэх" гэж заасны дагуу тушаал ирснээс хойш 7 хоногийн дотор НЗД-ын захирамжаар ХАА-ны эрх шилжүүлэн ажилласан гэж зөвлөмжийн биелэлт ирүүлсэн ч хугацаандаа хэрэгжих боломжгүй хугацаанд эрх шилжүүлсэн ТАХ байна. Тухайлбал: 2021 оны 9 дугаар сарын 27-ны өдөр ХАА ажиллагааг зохион байгуулж эхэлсэн 12 ажил, 10 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан 1, 11 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулсан 2 ажил байна. Мөн мэргэжлийн байгууллагад эрх шилжүүлээгүй 2 ТАХ байна. Тухайлбал: УБ хотын захирагчийн ажлын алба 9, Ус сувгийн газар 1, ЭМГ 2 ажил зохион байгуулсан байна.

- 2. Эрх шилжүүлсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа ТАХ-д тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

ТАХ-ний санхүүжилтийн үлдэгдлийг барьцаа хөрөнгийн дансанд ЗГ-ын тогтоолд заасны дагуу байршуулах. Төсвийн тухай хуулийн 7.7; 43.5; 45.2-т заасны дагуу ТЕЗ-ийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн жил дуусахад төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ гэсэн заалтыг хэрэгжүүлж ажилласан байна. ТАХ-ний санхүүжилтийн үлдэгдлийг барьцаа хөрөнгийн дансанд ЗГ-ын тогтоолд заасны дагуу байршуулж байгаа гэж хариу ирсэн ба цаашид санхүүгийн хяналтыг тогтмол хэрэгжүүлэх, ТАХ-ний захиалагчийн хяналтыг сайжруулж, ашиглагч байгууллагын хариуцлагыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах хэрэгтэй байна.

- 3. ТАХ-ний худалдан авалт, гүйцэтгэлтэй холбоотой зөрчил жил бүр давтагдаж арилахгүй байгаад анхаарал хандуулж үнэлгээний хороо, захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн, байгууллага, албан тушаалтан, ашиглалтад хүлээн авах комисс, төрийн албан хаагчдын ажлын хариуцлагыг эрс сайжруулж, цаашид гаргахгүй байж зөрчлийг таслан зогсоох.

2021 оны хөрөнгө оруулалтын ажлыг төлөвлөх, зохион байгуулах, гэрээний хяналтыг хэрэгжүүлэхдээ албан үүргээ хангалтгүй биелүүлсэн албан тушаалтнуудад хариуцлага тооцож, танилцуулахыг холбогдох байгууллагуудад үүрэг болгож ТАХ-ний гүйцэтгэлийн явцад дотоод хяналтыг сайжруулан, НЗД-ын 2021 оны "Хөрөнгө оруулалтын ажлын зохион байгуулалтыг сайжруулах, хариуцлага тооцох" тухай захирамж гарсан байна.

4. ТАХ-ний санхүүжилтийн үлдэгдлийг барьцаа хөрөнгийн дансанд ЗГ-ын тогтоолд заасны дагуу байршуулах.

Төсвийн тухай хуулийн 7.7; 43.5; 45.2-т заасны дагуу ТЕЗ-ийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн жил дуусахад төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ гэсэн заалтыг хэрэгжүүлж ажилласан байна.

- 5. НХААГ, дүүргүүдийн ХААА-нд. /2021.09.30 1805, 2021.12.06 03/5485 албан тоотор НТАГ-т ирүүлсэн.

СС-ын 2014 оны 09 сарын 30-ны өдрийн "Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам болон шинээр

батлагдсан журам, заавар, аргачлалыг мөрдөн ажиллаж байна. "Тендерийн урилга, баримт бичгийг боловсруулахдаа холбогдох дарга нараар хянуулж ажиллаж байна. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа баримт бичгийг магадлахыг хурлуудаар үүрэг болгосон. Үнэлгээний хороодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор "ХАА-г зохион байгуулах, тайлагнах, архивлах журам", "ХАА-тай холбоотой жишиг баримт бичгийн үлгэрчилсэн заавар" тус тус боловсруулж ажилласан.

- 6. *Тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх талаар холбогдох байгууллагуудыг зөвлөгөө, мэдээллээр бүрэн хангаж, биелэлтэд хяналт тавих;*

ХАА-г 100% цахим системээр дамжуулан зохион байгуулж байгаа бөгөөд СС-ын 2019 оны 12 сарын 09-ний өдрийн 255-р тушаалаар батлагдсан "ХАА-ны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам"-ын 3.7-д заасны дагуу холбогдох мэдээллийг цахимаар татан шалгаж байна.

- 7. НХОГ ОНӨААТҮГ: *Сургууль, цэцэрлэгийн барилга угсралтын явцад тавих захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй, ажлыг дутуу болон чанаргүй гүйцэтгүүлсэн зөрчлийг арилгаж, стандартын шаардлагад нийцүүлэн засуулж, давтан гаргахгүй байх. /2021.12.01 2/3500 албан тоотоор НТАГ-т ирүүлсэн/*

Албан бичгээр 3 ТАХ-ний хэрэгжилтийн биелэлтийг ирүүлсэн. 1."Морин Суварга" ХХК-ийн гүйцэтгэсэн ХУД-т байрлах 28-р цэцэрлэгийн барилгыг буулгаж шинээр барих 240 ортой ажлын зураг төслийг боловсруулан Барилга хөгжлийн төвийн магадлалаар хянан баталгаажсан. Барилга угсралтын ажлыг зургийн дагуу гүйцэтгэсэн. 2."Морин Суварга" ХХК-ийн гүйцэтгэсэн ХУД-т байрлах 189-р цэцэрлэгийн ажлыг бүрэн дуусгах хугацаатай шаардлагыг гүйцэтгэгчид хүргүүлэн зөрчлийг арилгасан. ХАА-тай холбоотой баримт бичгийг мөрдөж, чанаргүй хийгдсэн ажлын чанарыг сайжруулах, засварлах ажлыг гүйцэтгэгчээр хийлгүүлэн ашиглагч байгууллагад хүлээлгэн өгсөн. 3. Амины орон сууцны зориулалттай барилгыг 150 хүүхдийн цэцэрлэгийн зориулалттай болгон өөрчлөх ажил 2020 оны 05 сарын 19-ны өдрийн 2020/235 комиссын актаар баталгаажсан. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2020 оны 07 сарын 24-ны өдрийн 07/2037 дугаартай албан бичгээр тус барилгыг цэцэрлэгийн зориулалтаар ашиглах боломжтой гэсэн дүгнэлт гарч ашиглагч байгууллагад хүлээлгэн өгсөн гэж зөвлөмжийн дагуу дээрх ажлуудыг зохион байгуулсан байна.

**Дүгнэлт:** Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

#### **Б.5.4. Улсын төсвийн санхүүжилтээр эдийн засгийн өсөлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээнд хөрөнгө оруулсан уу?**

2021 онд барилга, бүтээн байгуулалттай холбоотой 21,542.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 23 ТАХ-г баталснаас 16,815.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 ТАХ нь боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх сургууль, цэцэрлэгийн байна.

Харин эмнэлгийн хүчин чадлыг сайжруулах зорилгоор тоног төхөөрөмж нийлүүлэх 2,716.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 ТАХ-г баталсан байна.

Энэхүү хэрэгцээ шаардлагад тулгуурласан ажлын байрыг нэмэгдүүлэх зорилго бүхий 20 ТАХ нь 2021 онд баталсан нийт ТАХ-ний 23.6%-ийг эзэлж байна. Харин нийт ТАХ-ний 76.4% нь эдийн засгийн өсөлтийг дэмжихгүй засвар, тохижилтын ажилд хөрөнгө оруулсан байна. Жишээлбэл:

- Хүн амын эрүүл мэндэд ээлтэй эко ариун цэврийн байгууламж /УБ, СБД, 18 дугаар хороо/
- Нийтийн эзэмшлийн орон сууцны орцын их засвар /УБ, СБД, 5 дугаар хороо/

- Нийтийн эзэмшлийн орон сууцын гадна фасадын засвар /УБ, СБД, 7, 8, 10 дугаар хороо/
- Орон сууцын байруудын дундах тохижилт /УБ, БНД, 74, 75, 76, 77, 78, 79, 80, 81, 82, 83, 84 дүгээр байр/
- 108 дугаар цэцэрлэгийн дээврийн их засвар /УБ, ЧД/ гэх мэт.

**Дүгнэлт:** Улсын төсвийн санхүүжилтээр эдийн засгийн өсөлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээнд хөрөнгө оруулалт хийгээгүй байна.

#### **Б.5.5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үр нөлөөгөөр дэд бүтцийн салбарын хүчин чадал нэмэгдсэн үү?**

Нийслэлд шинээр хэрэгжүүлэхээр эрх шилжиж ирсэн 93 ТАХ-ээс 32,298.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 24 ТАХ-г дэд бүтцийн салбарт хэрэгжүүлэхээр баталжээ.  
**ХҮСНЭГТ №30. ДЭД БҮТЦИЙН САЛБАРТ ХЭРЭГЖИЖ БУЙ ТАХ**

№	ТЕЗ	Барилга		Авто зам		Инженерийн шугам сүлжээ		Нийт ТАХ	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
		/сая.төг/							
1	БОАЖС	1	2,900.0	-	-	-	-	1	2,900.0
2	БХБС	-	-	-	-	6	8,970.0	6	8,970.0
3	БШУС	6	12,480.0	-	-	2	60.0	8	12,540.0
4	ЗГХЭГ	1	1,500.0	-	-	-	-	1	1,500.0
5	ЗТХС	-	-	7	6,338.0	-	-	7	6,338.0
6	СС	-	-	-	-	-	-	-	-
7	ХНХЯ	1	50.0	-	-	-	-	1	50.0
8	ЭМЯ	-	-	-	-	-	-	-	-
	<b>Нийт дүн</b>	<b>9</b>	<b>16,930.0</b>	<b>7</b>	<b>6,338.0</b>	<b>8</b>	<b>9,030.0</b>	<b>24</b>	<b>32,298.0</b>

2021 онд хэрэгжиж дууссан ТАХ-ний 9.9%-г дэд бүтцийн салбарын хөрөнгө оруулалт байна. Дэлгэрэнгүйг хавсралтаар. Жишээ нь:

- Баянхошууны Баруун салааны авто замаас цэцэрлэг, сургуулийн цогцолбор хүртэлх авто зам, 1.0 км /УБ, СХД, 24 дүгээр хороо/
  - Хувьсгалчдын гудамжнаас 105 дугаар сургууль, Гүнжийн нуурыг дайраад 7 дугаар хорооны авто зам хүртэлх авто зам, 1.7 км /УБ, СХД/
  - Соёл, спорт, аялал жуулчлалын цогцолборын хувцас солих байр, тусламж үйлчилгээ, нийтийн соёл үйлчилгээний барилга байгууламж, өвлийн спортын талбай /УБ, ЧД, 19 дүгээр хороо, дээд Салхит/
  - Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /УБ, СБД, 11 дүгээр хороо/
- 2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар:
- 510 ортой цэцэрлэгийн барилга;
  - 180 хүүхдийн суудалтай суудалтай сургуулийн барилга;
  - Сургууль, цэцэрлэгийн өргөтгөл;
  - 3.5 км бүхий зам, гудамж, хорооллын авто замын засвар, шинэчлэлийн ажлуудыг бүрэн гүйцэтгэж дууссан байна.

**Дүгнэлт:** 2021 онд хэрэгжиж дууссан 24 ТАХ-ний хүрээнд дэд бүтцийн салбарын хүчин чадал нэмэгдсэн байна.

---

## АУДИТЫН ДҮГНЭЛТ

---

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ нь Улсын хөгжлийн бодлоготой уялдаагүй, хэрэгцээ шаардлагад нийцүүлж эрэмбэлэгдээгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй байна.
2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөвлөлтийн шаардлага хангуулж газрын байршлыг тогтоогоогүй, газар бүрэн чөлөөлөөгүй, зураг төсөв хийгдээгүй, ажлын даалгавар батлуулаагүй ТАХ-г баталснаас худалдан авах ажиллагаа төлөвлөсөн хугацаандаа зарлагдахгүй ,болж энэ нь ТАХ-ний гэрээний хэрэгжилт удааширч төсөвт өртөг нэмэгдэх эрсдэлийг үүсгэж байна.
3. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих ТАХ-ний хэрэгцээ шаардлага эрэмбийг зөв тогтоогүй, хэрэгцээ шаардлагагүй болон хэрэгцээ шаардлагаас бага хүчин чадалтай ТАХ-г хэрэгжүүлсэн.
4. Зураг төсөв шаардлагатай барилга байгууламжийн ТАХ-ний төсвийг батлахдаа загвар зураг ашигласнаас зураг төсөв өөрчлөгдөж хугацаа алдах, төсөвт өртөг нэмэгдэх шалтгаан болсон байна.
5. Захиалагчийн болон зохиогчийн хяналт хэрэгжүүлж байгаа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлээгүй, нэгдсэн судалгаа, тайлан мэдээ байхгүй, хяналтын оновчтой тогтолцоо бүрдээгүй байна.
6. Хөрөнгө оруулалтын санхүүжилтийг батлахдаа өмнөх оноос дамжин хэрэгжих ТАХ-ний санхүүжилтийг гүйцэд батлаагүйгээс ТАХ-ний хэрэгжилт удааширч төсөвт өртөг нэмэгдсэн.

---

## АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

---

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:  
**Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч /Д.Сумъяабазар/-д:**

1. Он дамжсан, орхигдсон барилга, байгууламжийг дуусгах талаар холбогдох газруудад санал хүргүүлэн ажлын уялдааг сайжруулж, шийдвэрлэх.
2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө хэрэгцээ шаардлага, эрэмбийг зөв тогтоож, улс болон нийслэлийн төсвийн зориулалт, уялдааг анхаарч санал өгөх.
3. Өмнөх жилүүдийн аудитаар илэрсэн захиалагчийн үйл ажиллагаатай холбоотой алдаа зөрчлүүд арилахгүй давтагдан хууль, журмыг ноцтой зөрчиж байгаа тул захиалагчийн болон зохиогчийн чиг үүрэг, хяналт хэрэгжүүлж байгаа НЗД-ын орлогч, НЗДТГ, мэргэжлийн болон чиглэлийн байгууллага, нэгжийн үйл ажиллагааны үр дүнг сайжруулах, сахилга батыг дээшлүүлэх, хариуцлагыг тооцох зохион байгуулалтын цогц арга хэмжээг авах.

### **НХААГ, дүүргүүдийн ХААА-нд**

1. Өмнөх жилүүдийн аудитаар илэрсэн алдаа зөрчлүүд арилахгүй давтагдан хууль, журмыг ноцтой зөрчиж байгаа тул мэргэжлийн алдаа, дутагдал гаргахгүйгээр үйл ажиллагааны үр дүнг сайжруулах, сахилга батыг дээшлүүлэх, хариуцлага тооцох арга хэмжээг авах.
2. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулахгүй байх.

### **НХОГ ОНӨААТҮГ-т**

1. Зураг төсөл зохиогчийн хяналтыг сайжруулж, тайлан мэдээг нэгтгэн дүгнэх.
2. ТАХ-ний гүйцэтгэлийн хувийг бодитой тооцох аргачлалыг боловсруулж, эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх.
3. Гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь чанартай хангуулах талаар онцгой анхаарч ажиллах.

### **ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАР-т /"ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР"-аар уламжлуулан хүргүүлэх/**

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө нийслэлийн саналыг харгалзаж, хэрэгцээ шаардлагыг тодорхойлон төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл арга хэмжээний эрхийг шилжүүлэх.
2. Өмнөх жилүүдэд төсөвлөлтийн шаардлага хангаагүйгээс он дамжсан, орхигдсон барилга, байгууламжийг нийслэлтэй хамтран дуусгах, төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-г төлөвлөхгүй байх.

# ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



Нийслэл дэх Төрийн Аудитын газраас  
"Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн /АГТ-2022/16-ШТА-ГА/ гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад тусгайлан өгөх саналгүй болно.

ДАРГА Т.ОЮУНЧИМЭГ



D:\2022 он\Wlan bichag\TG\_A5.docx  
111020061795



"Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" /АГТ-2022/16-11-ШТА-ГА/-ийн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа.  
Танай ирүүлсэн аудитын тайлангийн төсөлтэй санал нэг байна.




2022.04.26 № 5/822  
Төвийн 2022.04.21 -ны № 878

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

"Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын 2022 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн 878 тоот албан бичгээр ирүүлсэн тайлангийн төсөлтэй танилцлаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих төсөл, арга хэмжээний талаархи аудитын тайлангийн төсөлд тусгах санал байхгүйг үүгээр уламжилж байна.



---

## САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

---

НЗДТГ-ын 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 03/205 дугаар албан бичгээр тайлангийн төсөлд тусгах саналгүй байгааг илэрхийлсэн.

НХААГ-ын 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 5/822 дугаар албан бичгээр аудитын тайлангийн төсөлд тусгах саналгүй байгааг илэрхийлсэн.

НХОГ-ын 2022 оны 04 дүгээр сарын 27-ны 2/1511 дүгээр албан бичгээр аудитын тайлангийн төсөлд тусгах саналгүй байгааг илэрхийлсэн.

**ХАВСРАЛТ №1. ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГААС БАГА ТАХ-НИЙ ЖАГСААЛТ**

№	Хуулийн дугаар	ТЭЗ	ТАХ-ний нэр	ТАХ-ний төрөл	Төсөвт өртөг /сая.төг/	Санхүүжих өртөг /сая.төг/
1	XV.3.2.1	ЗТХЯ	Автобусны буудлын тохижилт /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	тохижилт	1,342.0	403.0
2	XV.1.1.18.4	ЗТХЯ	Туул голын эрэг дагуу аялал жуулчлалын дэд бүтцийг байгуулах, зогсоол, гэрэлтүүлэг, хяналтын байр барих (Улаанбаатар, Баянзүрх дүүрэг)	тохижилт	250.0	250.0
3	XV.1.1.18.6	ЗТХЯ	Зам, тээврийн хөгжлийн салбарын Улаанбаатар хотод хийгдэх хөрөнгө оруулалт (Улаанбаатар) Гачууртаас Гүнжийн хоолой хүртэлх авто замын хоолой зураг төсөл (Улаанбаатар)	зам засвар	60.0	60.0
4	XV.1.2.10	ЗТХЯ	Автобусны буудлын зогсоолын шинэчлэл (Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20 дугаар хороо)	тохижилт	1,000.0	500.0
5	XV.1.1.18.5	ЗТХЯ	Зам, тээврийн хөгжлийн салбарын Улаанбаатар хотод хийгдэх хөрөнгө оруулалт (Улаанбаатар) Хороодын явган хүний зам, шороон замын засвар (Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг)	зам засвар	474.5	474.5
6	XV.1.2.7	ЗТХЯ	Хорооллын доторх авто замын засвар, шинэчлэл /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 12 дугаар хороо, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21, 24, 25, 26, 27, 28, дугаар байр/	зам засвар	50.0	50.0
7	XV.1.1.42	ЗТХЯ	Хувьсгалчдын гудамжнаас 105 дугаар сургууль, Гүнжийн нуурыг дайраад 7 дугаар хорооны авто зам хүртэлх авто зам, 1.7 км /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	зам засвар	2,400.0	2,350.0
8	XIII.3.1.2.1	БШУЯ	Мал эмнэлгийн хүрээлэнгийн засвар /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	барилга засвар	50.0	50.0
9	XIII.3.1.2.38	БШУЯ	92 дугаар сургуулийн Б-блокны дээврийн их засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	барилга засвар	30.0	30.0
10	XIII.3.1.2.39	БШУЯ	79 дүгээр сургуулийн дээврийн их засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	барилга засвар	40.0	40.0
11	XIII.3.1.2.40	БШУЯ	44 дүгээр цэцэрлэгийн барилгын их засвар /Улаанбаатар, Багахангай дүүрэг/	барилга засвар	70.0	70.0
12	XIII.3.1.2.41	БШУЯ	Эрдмийн оргил цогцолбор сургуулийн дотуур байрны цахилгаан, сантехникийн засвар /Улаанбаатар, Налайх дүүрэг/	цахилгаан сантехник завсар	50.0	50.0
13	XIII.3.1.2.42	БШУЯ	123 дугаар цэцэрлэгийн дотор сантехникийн их засвар /Улаанбаатар, Налайх дүүрэг/	сан техникийн завсар	25.0	25.0
14	XIII.3.1.2.44	БШУЯ	52 дугаар сургуулийн барилгын дээвэр, гал тогоо, шалны их засвар /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	барилга засвар	70.0	70.0
15	XIII.3.1.2.45	БШУЯ	59 дүгээр сургуулийн барилгын сантехник, шалны их засвар /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	сан техникийн завсар	30.0	30.0

16	XIII.3.1.2.46	БШУЯ	108 дугаар цэцэрлэгийн дээврийн их засвар /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	барилга засвар	40.0	40.0
17	XIII.3.1.2.47	БШУЯ	24 дүгээр сургуулийн 1 дүгээр давхрын их засвар /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	барилга засвар	50.0	50.0
18	XIII.3.1.2.48	БШУЯ	167 дугаар цэцэрлэгийн гадна шугамын их засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	барилга засвар	20.0	20.0
19	XIII.3.1.2.49	БШУЯ	Эрдмийн ундраа цогцолбор сургуулийн 2 дугаар байрны дээврийн их засвар /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	барилга засвар	30.0	30.0
20	XIII.3.1.2.50	БШУЯ	Сэтгэмж цогцолбор сургуулийн байрны цахилгаан, сантехникийн их засвар /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	сан техникийн завсар	50.0	50.0
21	XIII.3.1.2.53	БШУЯ	164 дүгээр цэцэрлэгийн барилгын засвар /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	барилга засвар	50.0	50.0
22	XIII.3.1.2.54	БШУЯ	132 дугаар цэцэрлэгийн засвар /Улаанбаатар, Багануур дүүрэг/	барилга засвар	30.0	30.0
23	XIII.1.2.35	БШУЯ	Цэцэрлэгийн гадна хашаа /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 11 дүгээр хороо, 200 дугаар цэцэрлэг/	тохижилт	11.0	11.0
24	XIII.1.2.36	БШУЯ	Цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, сувилал яслийн 10 дугаар цогцолбор/	барилга засвар	50.0	50.0
25	XIII.1.3.14	БШУЯ	Сургуулийн автобус /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 11 дүгээр хороо, 88 дугаар сургууль/	автобус	60.0	60.0
26	XII.2.17	БХБЯ	Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 13, 14 дүгээр хороо/	тохижилт	80.0	30.0
27	XIII.1.2.39	БШУЯ	Сургуулийн барилгын дээврийн засвар /Улаанбаатар, Багануур дүүрэг, Боловсрол цогцолбор сургууль/	барилга засвар	145.3	145.3
28	XIII.1.2.40	БШУЯ	Цэцэрлэгийн цонх, дээврийн засвар /Улаанбаатар, Багануур дүүрэг 138 дугаар цэцэрлэг/	барилга засвар	67.4	67.4
29	XIII.1.2.41	БШУЯ	Цэцэрлэгийн барилгын эх засвар /Улаанбаатар, Багануур дүүрэг, 142 дугаар цэцэрлэг/	барилга засвар	105.3	105.3
30	XIII.3.1.2.43	БШУЯ	107 дугаар цэцэрлэгийн сантехникийн их засвар /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	сан техникийн завсар	25.0	25.0
31	XII.2.29	БХБЯ	Орон сууцны фасадын дулаалга, дээврийн их засвар /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 12, 13, 14, 15, 16, 17 дугаар хороо/	барилга засвар	1,000.0	1,000.0
32	XII.1.84	БХБЯ	Олон улсын стандартад нийцсэн хүүхдийн тоглоомын талбай /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 18, 19, 20 дугаар хороо/	тохижилт	1,500.0	500.0
33	XII.1.85	БХБЯ	Хүн амын эрүүл мэндэд ээлтэй эко ариун цэврийн байгууламж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 18 дугаар хороо/	эко оо	1,000.0	500.0
34	XII.1.86	БХБЯ	Гэрэлтүүлэг, камержуулалт /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 15, 16, 17, 18, 19, 20 дугаар хороо/	тохижилт	800.0	800.0

35	XII.1.87	БХБЯ	Хорооны тохижилт /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 18 дугаар хороо/	тохижилт	200.0	200.0
36	XII.2.35	БХБЯ	Жишиг хороо байгуулах, тохижилт /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 14 дүгээр хороо/	тохижилт	500.0	200.0
37	XII.2.36	БХБЯ	Нийтийн эзэмшлийн орон сууцны барилгуудын гадна дулаалга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	барилга засвар	1,730.0	1,730.0
38	XII.2.37	БХБЯ	Нийтийн эзэмшлийн орон сууцны орцын их засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 5 дугаар хороо/	барилга засвар	115.5	115.5
39	XII.2.39	БХБЯ	Нийтийн эзэмшлийн орон сууцны гадна фасадын засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 7, 8, 10 дугаар хороо/	барилга засвар	1,000.0	1,000.0
40	XII.1.72	БХБЯ	Гэр хорооллын хөрсний бохирдлыг багасгах эко ариун цэврийн байгууламж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 11 дүгээр хороо/	эко оо	170.5	170.5
41	XII.1.82	БХБЯ	Орон сууцны байруудын дундах тохижилт /Улаанбаатар, Багануур дүүрэг 74, 75, 76, 77, 78, 79, 80, 81, 82, 83, 84 дүгээр байр/	тохижилт	333.3	333.3
42	XII.1.83	БХБЯ	Халуун усны барилга /Улаанбаатар, Багануур дүүрэг, 4 дүгээр хороо/	барилгын засвар	178.6	178.6
43	XII.2.33	БХБЯ	Нийтийн эзэмшлийн орон сууцуудын дээврийн засвар /Улаанбаатар, Багануур дүүрэг, 1, 3 дугаар хороо/	барилга засвар	450.0	450.0
44	XII.2.34	БХБЯ	Төмөр замын байрын орцын засвар /Улаанбаатар, Багануур дүүрэг/	барилга засвар	60.0	60.0
45	XII.1.81	БХБЯ	Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн гэрэлтүүлэг /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	тохижилт	400.0	150.0
46	XII.1.92	БХБЯ	Тоглоомын талбайн тохижилт /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 20 дугаар хороо, 10 айл хэсэг, Гачуурт голын эрэг, Зүүн дэнжийн хойд тал/	тохижилт	100.0	100.0
47	XII.1.93	БХБЯ	Тоглоомын талбайн тохижилт /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 3 дугаар хороо, 50 дугаар цэцэрлэг/	тохижилт	45.0	45.0
48	XII.1.112	БХБЯ	"Жишиг гудамж" төсөл /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 28 дугаар хороо/	тохижилт	2,500.0	1,000.0
49	XII.2.42	БХБЯ	Орон сууц дээврийн их засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 3 дугаар хороо, 1, 9, 51, 56 дугаар байр/	барилга засвар	200.0	200.0
50	XII.4.6	БХБЯ	Хорооны төлөвлөлтийн зураг, төсөв /Улаанбаатар, Багануур дүүрэг, 2, 5 дугаар хороо	зураг төсөл	150.0	150.0
51	XII.4.8	БХБЯ	Гэр хорооллын гэрэлтүүлгийн зураг, төсөв /Улаанбаатар, Багануур дүүрэг/	зураг төсөл	110.0	110.0
52	XIII.3.1.2.70	БШУЯ	Дотуур байрны гадна дулааны шугам сүлжээний засвар (Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 11 дүгээр хороо, 29 дүгээр сургуулийн дотуур байр)	инженерийн шугам сүлжээ	40.0	40.0

53	XIII.3.1.2.71	БШУЯ	Цэцэрлэгийн барилгын засвар (Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, сувилал яслийн 10 дугаар цогцолбор)	барилга засвар	60.0	60.0
54	XIX.2.3.26	ЭМЯ	Эрүүл мэндийн төвийн засвар (Улаанбаатар, Багануур дүүрэг)	барилгын засвар	200.0	200.0

## ХАВСРАЛТ №2. САНХҮҮЖИЛТИЙГ ХЭРЭГЖИХ БОЛОМЖГҮЙ БАЙДЛААР БАТАЛСАН ТАХ-НИЙ ЖАГСААЛТ

Д/Д	ТЕЗ	Хуулийн код	Барилга байгууламж, их засварын ажлын нэр, хүч чадал, байршил	Эхлэх дуусах хугацаа	Батлагдсан төсөвт өртөг	Гэрээний дүн	2020 оны жилийн эцсийн санхүүжилтийн үлдэгдэл	2021 онд санхүүжих	Санхүүжилт %-иар
1	МУЕС, БТСУХ	III.1.1.3	Оюуны спортын ордны барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2018-2021	4,000.0	3,685.9	2,550.0	950.0	37
2	МУЕС, БТСУХ	III.1.1.25	Хөл бөмбөгийн талбай бүхий спортын цогцолбор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 3 дугаар хороо/	2021-2022	5,000.0	4,650.6	4,650.6	1,000.0	22
3	МУС, ЗГХЭГ-ын дарга	V.1.1.23	Хорооны цогцолборын барилга худалдан авах /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 24 дүгээр хороо/	2020-2022	1,500.0	1,500.0	1,500.0	700.0	47
4	БХБС	XII.1.6.3	Төвлөрсөн дулаан хангамжийн нэгдсэн системд холбогдох боломжгүй алслагдсан халаалтын зуухыг шинэчлэх, байгальд ээлтэй технологи, нэмэлт тоноглол суурилуулах	2020-2022	500.0	474.5	474.5	100.0	21
5	БХБС	XII.1.6.8	Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай 6, 7, 8 дугаар байрыг дахин барилгажуулах төслийн гадна инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажил /БЗД, 16 дугаар хороо/	2020-2022	629.4	588.5	588.5	128.4	22
6	БХБС	XII.1.6.12	Хүрхрээ эко хотхоны гэрэлтүүлэг /БЗД, 11 дүгээр хороо/	2020-2021	100.0	88.8	77.5	11.2	14
7	БХБС	XII.1.6.12	Зүрх-Уулын 6, 7, 8, 9 дугаар гудамж, Баянхайрхан 1, 2 дугаар гудамжны гэрэлтүүлэг /ЧД, 17 дугаар хороо/	2020-2021	120.0	94.7	66.1	28.6	43
8	БХБС	XII.1.6.12	Энгэр шандын гэр хорооллын гэрэлтүүлэг /НД, 1 дүгээр хороо/	2020-2021	150.0	125.5	83.4	42.1	50
9	БХБС	XII.1.17	Жишиг гудамж төсөл-2 /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 14 дүгээр хороо/	2020-2022	3,300.0	3,189.9	3,189.9	1,000.0	31
10	БХБС	XII.1.23	Нийтийн эзэмшлийн орон сууцны байруудын дулааны шугам сүлжээ, дэд станц /Улаанбаатар, Хан-	2018-2021	6,453.8	6,324.9	5,394.0	926.9	17

11	БХБС	XII.1.74	Уул дүүрэг, 11, 15 дугаар хороо/ Үерийн хамгаалалтын далан, 1.3 км /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 10, 28 дугаар хороо/	2021-2022	1,900.0	1,714.6	1,714.6	600.0	35
12	БХБС	XII.1.84	Олон улсын стандартад нийцсэн хүүхдийн тоглоомын талбай /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 18, 19, 20 дугаар хороо/	2021-2022	1,500.0	1,489.0	1,489.0	500.0	34
13	БХБС	XII.1.101	Цэвэр, бохир усны шугам сүлжээ /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 3, 4, 26, 36 дугаар хороо/	2021-2022	4,500.0	4,397.5	4,397.5	1,000.0	23
14	БХБС	XII.2.10	Нийтийн эзэмшлийн орон сууцын гадна фасадын их засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 7, 8, 10 дугаар хороо/	2020-2021	400.0	379.7	280.0	120.0	43
15	БХБС	XII.2.14	Нийтийн эзэмшлийн орон сууцын орцын их засвар /Улаанбаатар, Багануур дүүрэг, 1 дүгээр хороо/	2020-2021	150.0	147.0	100.0	50.0	50
16	БХБС	XII.2.22	Орон сууцын дээвэр, гадна фасадын засвар /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 6 дугаар хороо, 58а, 58б, 58в, 58г байр/	2020-2021	1,000.0	901.3	700.0	300.0	43
17	БХБС	XII.2.35	Жишиг хороо байгуулах, тохижилт /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 14 дүгээр хороо/	2021-2022	500.0	465.2	465.2	200.0	43
18	БШУС	XIII.1.1.12	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 12 дугаар хороо/	2018-2021	3,506.5	3,454.5	2,517.6	600.0	24
19	БШУС	XIII.1.1.28	Сургуулийн барилга буулгаж, шинээр барих, 640 суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 19 дүгээр сургууль/	2018-2022	6,965.8	6,965.8	4,877.2	50.0	1
20	БШУС	XIII.1.1.54	Сургуулийн барилга, 480 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг 20 дугаар хороо/	2019-2022	5,851.8	5,704.6	2,214.6	50.0	2
21	БШУС	XIII.1.1.65	Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 4 дүгээр хороо/	2018-2022	6,166.6	5,610.3	4,600.0	1,566.6	34
22	БШУС	XIII.1.1.96	Сургуулийн барилгын өргөтгөл, 640 суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг, Эрдмийн өргөө цогцолбор сургууль/	2018-2022	5,424.9	3,831.0	3,075.9	50.0	2

23	БШУС	XIII.1.1.105	Сургуулийн дотуур байрын барилга, 70 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 21 дүгээр хороо/	2020-2021	1,300.0	1,246.5	1,246.5	600.0	48
24	БШУС	XIII.1.1.119	Сургууль, цэцэрлэгийн цогцолбор худалдан авах /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 29 дүгээр хороо/	2020-2022	13,100.0	1,246.5	11,000.0	2,100.0	19
25	БШУС	XIII.1.1.149	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 11 дүгээр хороо/	2018-2022	1,803.0	1,802.9	1,099.5	50.0	5
26	БШУС	XIII.1.1.157	Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 21 дүгээр хороо/	2018-2021	2,441.2	2,441.2	1,746.5	241.2	14
27	БШУС	XIII.1.1.158	Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 8 дугаар хороо, Гангар инвест/	2019-2021	2,500.0	2,389.6	2,000.0	400.0	20
28	БШУС	XIII.1.1.159	Цэцэрлэгийн барилга, 240 ор /Баянзүрх дүүрэг, 8 дугаар хороо, Харуул-Алтай хотхон/	2019-2022	2,781.9	2,777.7	1,901.2	50.0	3
29	БШУС	XIII.1.1.163	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 4 дүгээр цэцэрлэг/	2018-2022	2,292.8	2,282.8	1,758.9	50.0	3
30	БШУС	XIII.1.1.185	Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 9 дүгээр хороо/	2018-2022	4,153.8	3,696.8	3,343.0	50.0	1
31	БШУС	XIII.1.1.186	Цэцэрлэгийн барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 12 дугаар хороо/	2019-2022	1,674.4	1,674.3	1,477.1	50.0	3
32	БШУС	XIII.1.1.190	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 16 дугаар хороо/	2019-2022	1,609.5	1,609.4	1,299.9	50.0	4
33	БШУС	XIII.1.1.207	Сургуулийн барилгын өргөтгөл /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр сургууль/	2018-2021	3,548.4	3,403.5	2,355.1	1,048.4	45
34	БШУС	XIII.1.1.208	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 22 дугаар хороо/	2018-2022	1,788.8	1,788.8	1,388.0	50.0	4
35	БШУС	XIII.1.1.213	Цэцэрлэгийн барилга худалдан авах /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 2 дугаар хороо/	2021-2022	2,000.0	1,950.0	1,950.0	875.0	45
36	БШУС	XIII.1.1.238	Сургуулийн барилгыг буулгаж, шинээр барих, 960 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 18 дугаар хороо, 12 дугаар сургууль/	2021-2022	7,300.0	6,775.0	6,775.0	1,050.0	15
37	БШУС	XIII.1.1.239	Тусгай хэрэгцээт хүүхдийн цэцэрлэгийн барилга /Улаанбаатар,	2021-2022	4,000.0	3,720.1	3,720.1	500.0	13

38	БШУС	XIII.1.1.240	Сонгинохайрхан дүүрэг/ Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 7 дугаар хороо/	2021-2022	1,750.0	1,745.0	1,745.0	500.0	29
39	БШУС	XIII.1.1.243	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 16 дугаар хороо/	2021-2022	1,400.0	1,376.6	1,376.6	420.0	31
<b>УЛСЫН ТӨСВИЙН НИЙТ ДҮН</b>					<b>115,062.6</b>	<b>97,710.4</b>	<b>91,188.4</b>	<b>18,058.4</b>	

### ХАВСРАЛТ №3. ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ ТАХ-НИЙ ЖАГСААЛТ

Д/Д	ТЭЗ	Захиалагчийн хяналт	Барилга байгууламж, их засварын ажлын нэр, хүч чадал, байршил	Зөрчлийн утга	Эхлэх дуусах хугацаа	Батлагдсан төсөвт өртөг	Гэрээний үнийн дүн	Олгосон санхүүжилт	/сая.төг/ Тендерт шалгарсан гүйцэтгэгч
1	МУЕС, БТСУХ	НХОГ	Хөл бөмбөгийн талбай бүхий спортын цогцолбор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 3 дугаар хороо/	Газар чөлөөлөлт дуусаагүйн улмаас ажил эхлээгүй	2021-2022	5,000.0	4,650.6	1,000.0	Аглут ХХК
2	МУС, ЗГХЭГ-ын дарга	НХОГ	Хорооны цогцолбор барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 10 дугаар хороо/	Газар чөлөөлөлтөөс болоод гэрээний хугацаа хойшилсон	2020-2022	1,800.0	1,795.2	1,000.0	Энх бизнес өгөөмж ХХК
3	МУС, ЗГХЭГ-ын дарга	НХОГ	Хорооны цогцолбор барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 9 дүгээр хороо/	Газар чөлөөлөлтөөс болоод гэрээний хугацаа хойшилсон	2020-2022	1,800.0	1,782.1	1,000.0	Эй Ди констракшн ХХК
5	БХБС	НХОГ	Үерийн хамгаалалтын далан, 1.3 км /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 10, 28 дугаар хороо/	Гэрээний хугацаанд ажил эхлээгүй	2021-2022	1,900.0	1,714.6	600.0	Мэлч Анд ХХК
6	БХБС	НХОГ	Үерийн ус зайлуулах суваг /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 8, 40 дүгээр хороо/	Гэрээний хугацаанд ажил эхлээгүй	2021	300.0	280.9	280.9	Тэмээн ХХК
7	БХБС	НХОГ	Гэр хорооллын хөрсний бохирдлыг багасгах экологи ариун цэврийн байгууламж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 11 дүгээр хороо/	Ажлын даалгаврын дагуу гүйцэтгээгүй	2021	170.5	164.6	500.0	Брэнд шилдэг ХХК
8	БХБС	НХОГ	Нийтийн эзэмшлийн орон сууцны гадна фасадын засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 7, 8, 10 дугаар хороо/	Орон сууцны байрыг хэсэгчлэн засахаар баталсан	2021	1,000.0	918.9	918.9	Моксан ХХК
9	БШУС	НХОГ	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор, 240 суудал /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг 19 дүгээр хороо/	Загвар зургаар төсөв баталснаас ажлын тоо хэмжээ өссөн. Хээрийн судалгааны	2019-2021	3,485.4	3,474.6	1,185.7	Саран инж.девелопмент ХХК

10	БШУС	НХОГ	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 12 дугаар хороо/	ажил хийгээгүй. Гэрээнд заасан хугацаанд ажил гүйцэтгээгүй, санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгоогүй	2018-2021	3,506.5	3,454.5	600.0	Хан-Аттрибут ХХК
11	БШУС	НХОГ	Сургуулийн барилга буулгаж, шинээр барих, 640 суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 19 дүгээр сургууль/	Санхүүжилт авсан эсэхийг тодруулах	2018-2022	6,965.8	6,965.8	50.0	Гэрэлтжин ХХК
12	БШУС	НХОГ	Сургуулийн барилга, 1200 суудал /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, Буянт-Ухаа 2 цогцолбор/	Төсөвт өртөг нэмэгдсэн, гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй	2019-2021	9,697.0	9,615.0	2,539.0	Вишн девелопмент ХХК
13	БШУС	НХОГ	Сургуулийн барилга, 320 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 31 дүгээр хороо/	Гэрээнд заасан хугацаанд ажил гүйцэтгээгүй.	2018-2021	4,000.0	3,227.7	1,800.0	Глобалрост ХХК
14	БШУС	НХОГ	Сургуулийн барилга, 480 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг 20 дугаар хороо/	Төсөвт өртөг нэмэгдсэн.	2019-2022	5,851.8	5,704.6	50.0	Жинст цамхаг ХХК
16	БШУС	НХОГ	Сургуулийн барилгын өргөтгөл, 640 суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг, Эрдмийн өргөө цогцолбор сургууль/	Зураг төслийн дагуу ажил гүйцэтгээгүй, гүйцэтгэлд үндэслэн санхүүжилт олгоогүй, төсөвт өртөг нэмэгдсэн	2018-2022	5,424.9	3,831.0	-	Солид констракшн ХХК
18	БШУС	НХОГ	Сургуулийн барилгыг буулгаж, шинээр барих, 960 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 18 дугаар хороо, 12 дугаар сургууль/	албан шаардлага, гэрээний хугацаанд ажил гүйцэтгээгүй	2021-2022	7,300.0	6,775.0	1,050.0	Морин сувд ХХК болон Жам ХХК-ийн түншлэл
19	БШУС	НХОГ	Тусгай хэрэгцээт хүүхдийн цэцэрлэгийн барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	Зураг төсөв батлагдаагүй, ажил эхлээгүй	2021-2022	4,000.0	3,720.1	500.0	Хүрэл Ордон ХХК болон И Пи Эс групп ХХК-ийн түншлэл
20	БШУС	НХОГ	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 7 дугаар хороо/	Зураг төсөв батлагдаагүй, ажил эхлээгүй	2021-2022	1,750.0	1,745.0	500.0	Инерци ХХК, Барилга менежмент ХХК-ийн түншлэл
21	БШУС	НХОГ	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 16 дугаар хороо/	Гэрээний дагуу ажил эхлээгүй	2021-2022	1,400.0	1,376.6	420.0	Танан цамхаг констракшн ХХК болон Зэндмэнэтүлга ХХК-иудын түншлэл
25	СС	НХОГ	Дүүргийн соёлын ордны барилга /Улаанбаатар,	Зураг төсвийн дагуу ажил гүйцэтгээгүй, ажлын тоо	2019-2021	14,532.8	15,834.4	7,182.8	Аглут ХХК

			Сонгинохайрхан дүүрэг, 5 дугаар хороо/	хэмжээ өссөн, гадна тохижилт болон тоног төхөөрөмж суурилуулах ажлын гүйцэтгэчийг тус нь тендер зарлаж шалгаруулснаас хугацаа алдсан					
26	ХХААХУ С	НХОГ	Зөөврийн усансан /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг	7 ширхэг худаг барихаас 3 худаг барьсан гэрээний хугацаанд ажил гүйцэтгээгүй.	2020-2021	600.0	510.0	300.0	Вивазоне ХХК
27	ЗТХС	НАЗХГ	Автобусны буудлын тохижилт /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	Гэрээний дагуу ажил гүйцэтгээгүй, зураг төсөв өөрчлөгдсөн, газар чөлөөлөлт болон газрын байршил тодорхойгүй, төсвийн задаргаа байхгүйгээс гүйцэтгэлийг дүгнэх боломжгүй	2021-2022	1,342.0	1,204.7	403.0	Цагаан толгойн нуур ХХК, И Пи Эс групп ХХК-ийн түншлэл
28	ЗТХС	НАЗХГ	Автобусны буудлын зогсоолын шинэчлэл (Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20 дугаар хороо)	Гэрээний дагуу ажил гүйцэтгээгүй, зураг төсөв өөрчлөгдсөн, газар чөлөөлөлт болон газрын байршил тодорхойгүй, төсвийн задаргаа байхгүйгээс гүйцэтгэлийг дүгнэх боломжгүй	2021-2022	1,000.0	879.4	500.0	Үүлэн сүндэр ХХК
29	ХНХС	ННТҮГ	Зам, тээврийн хөгжлийн салбарын Улаанбаатар хотод хийгдэх хөрөнгө оруулалт (Улаанбаатар) Нийтийн тээврийн парк шинэчлэлт	2 жил дараалан улсын төсөвт суугдаж барьцаа хөрөнгийн дансанд мөнгийг байршуулсан, гэрээнд заасан хугацаанд нийлүүлээгүй	2021	21,393.9	19,140.0	21,393.9	Сүлдэрхан минералс ххк болон Xia men golden dragon bus co ltd ХХК-иудын түншлэл

#### ХАВСРАЛТ №4. ДЭД БҮТЦИЙН САЛБАРТ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТАХ-НИЙ ЖАГСААЛТ

№	Захирамжийн огноо	ТЕЗ	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа	Төсөвт өртөг /сая.төг /
1	2021-03-15	БШУС	XIII.1.1.213	Цэцэрлэгийн барилга худалдан авах /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 2 дугаар хороо/ 150 ор	2021	2021	2,000.0
2	2020.03.25 2020.04.07	БОАЖ С	VI.1.6	Соёл, спорт, аялал жуулчлалын цогцолборын хувцас солих байр, тусламж үйлчилгээ, нийтийн соёл үйлчилгээний барилга байгууламж, өвлийн спортын талбай /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 19 дүгээр хороо, дээд Салхит/	2020	2021	2,900.0

3	2018.03.02 2019.04.16	БШУС	XIII.1.1.11	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 11 дүгээр хороо/ 120 ор, 180 суудал	2018	2021	2,840.0
4	2020.03.03	БШУС	XIII.1.1.105	Сургуулийн дотуур байрын барилга, 70 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 21 дүгээр хороо/	2020	2021	1,300.0
5	2018.03.02 2021.06.25	БШУС	XIII.1.1.157	Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 21 дүгээр хороо/	2018	2021	2,441.2
6	2020.03.03	БШУС	XIII.1.1.182	Цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын хүзүүвч /Улаанбаатар, Хан-уул дүүрэг, 189 дүгээр цэцэрлэг/	2020	2021	350.0
7	2018.03.02 2021.08.05	БШУС	XIII.1.1.207	Сургуулийн барилгын өргөтгөл /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр сургууль/	2018	2021	3,548.4
8	2021-03-03	ЗГХЭГ	V.1.1.23	Хорооны цогцолборын барилга худалдан авах (Улаанбаатар, Баянгол дүүрэг, 24 дүгээр хороо)	2021	2021	1,500.0
9	2021-03-15	ХНХЯ	XI.4.2.1	Ахмадын байрын өргөтгөлийн барилгын их засвар /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 11 дүгээр хороо/	2021	2021	50.0
10	2020.03.06 2020.10.12	ЗТХС	XV.1.1.11	Баянхошууны Баруун салааны авто замаас цэцэрлэг, сургуулийн цогцолбор хүртэлх авто зам, 1.0 км /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 24 дүгээр хороо/	2020	2021	1,395.5
11	2020.02.27 2020.10.12	ЗТХС	XV.1.1.33	Толгойтын замаас Хүнсчидийн гудамжтай холбох хатуу хучилттай авто зам, 0.8 км /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 4 дүгээр хороо/	2020	2021	1,200.0
12	2020.02.27 2020.10.12 2021.03.03	ЗТХС	XV.1.1.42	Хувьсгалчдын гудамжнаас 105 дугаар сургууль, Гүнжийн нуурыг дайраад 7 дугаар хорооны авто зам хүртэлх авто зам, 1.7 км /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2020	2021	2,400.0
13	2020.03.06 2020.10.12	ЗТХС	XV.1.1.50	Сурагчийн 49 дүгээр гудамжны авто зам /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2020	2021	740.0
14	2020.02.27 2020.10.12 2021.03.03	ЗТХС	XV.1.2.7.1	Хорооллын доторх авто замын засвар, шинэчлэл /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 12 дугаар хороо, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21, 24, 25, 26, 27, 28 дугаар байр/	2020	2021	492.0
15	2021-03-03	ЗТХС	XV.1.1.18.6	Зам, тээврийн хөгжлийн салбарын Улаанбаатар хотод хийгдэх хөрөнгө оруулалт (Улаанбаатар) Гачууртаас Гүнжийн хоолой хүртэлх авто замын хоолой зураг төсөл (Улаанбаатар)	2021	2021	60.0
16	2021-03-03	ЗТХС	XV.1.2.7	Хорооллын доторх авто замын засвар, шинэчлэл /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 12 дугаар хороо, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21, 24, 25, 26, 27, 28, дугаар байр/	2021	2021	50.0

17	2020.04.20 2020.06.12 2020.10.07 2021.03.25	БХБС	XII.1.6.8.3	Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай 27 дугаар байрыг дахин барилгажуулах төслийн гадна инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажил /БГД, 17 дугаар хороо/	2020	2021	421.4
18	2018.04.06 2019.03.22 2019.12.12 2020.03.10 2020.03.13 2020.10.07 2021.03.25	БХБС	XII.1.23	Нийтийн эзэмшлийн орон сууцын байруудын дулааны шугам сүлжээ, дэд станц /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 11, 15 дугаар хороо/	2018	2021	6,453.8
19	2020-12-23	БХБС	XIII.3.1.2.5 1	Хан-Уул дүүргийн 5 дугаар хороо, 41 дүгээр сургууль, 29, 71-р цэцэрлэгийг төвлөрсөн дулаан хангамжид холбох	2021-06-17	2021-08-31	885.0
20	2020-12-23	БХБС		Баянзүрх дүүргийн 10 дугаар хороо, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 421 дүгээр нээлттэй хорих ангийг төвлөрсөн дулаан, хүйтэн ус хангамжид холбох	2021-06-16	2021-08-31	930.8
21	2020-12-23	БХБС		Хан-Уул дүүргийн 7, 8 дугаар хороо, 60, 118 дугаар сургууль, 209, 73 дугаар цэцэрлэгийг төвлөрсөн дулаан хангамжид холбох дулаан дамжуулах төвийн ажил	2021	2021	124.2
22	2021-03-25	БХБС	XII.2.38	Нийтийн эзэмшлийн орон сууцын үндсэн магистраль шугамын их засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 2 дугаар хороо/	2021	2021	154.5
23	2021-09-10	БХБС	XIII.3.1.2.7 0	Дотуур байрны гадна дулааны шугам сүлжээний засвар (Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 11 дүгээр хороо, 29 дүгээр сургуулийн дотуур байр)	2021	2021	40.0
24	2021-03-15	БШУС	XIII.3.1.2.4 8	167 дугаар цэцэрлэгийн гадна шугамын их засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2021	2021	20.0